



# СОЁМБО



БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТӨВ ХЭВЛЭЛ

2020.01.09 №01 (10678)

Үнэ 500 төгрөг

ГЭРЭЛ ЗУРАГ-НЭГ АГШИН

Дугаар эрхэлсэн хошууч Д.ОЮУНГЭРЭЛ



Гэрэл зургийг ахлагч Г.БАТ-ЭРДЭНЭ

Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн станцын дарга-жолооч, ахлах ахлагч Б.Отгонбаатар, ахлах радиотелеграфчин, олон улсын хэмжээний мастер, ахлагч Н.Орлого нар бүл нэмж, шинэ оноо угтлаа.

## ШИНЭ ОНЫ БОСГОН ДЭЭР ...

Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний 108 жилийн ойг тохиолдуулан шинэ жилийн босгон дээр Батлан хамгаалах, Зэвсэгт хүчинд олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж байгаа зарим офицер, ахлагч, ажилтан албан хаагч болон бэлтгэл, чөлөөнд байгаа ахмадуудыг төрийн дээд одон, медалиар шагналаа.

**Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор** Цэргийн төв эмнэлгийн Гэмтлийн клиникийн захирал, дэд хурандаа Т.Сүхбаатар, ҮБХИС-ийн ахмад багш Б.Дондог, Зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн ахмад ажилтан, бэлтгэл хошууч Д.Пунцаг, **Цэргийн гавьяаны одонгоор** ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын мэргэжилтэн, дэд хурандаа Д.Эрдэнэбилэг, Зэвсэгт хүчний 017 дугаар ангийн засварчин асан, бэлтгэл ахлах ахлагч Н.Эрдэнэцэцэг нарын зургаан хүн, **Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор** Зэвсэгт хүчний 353 дугаар ангийн нягтлан бодогч Х.Алтанзул, "Алтан гадас" одонгоор Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн нягтлан бодогч Ж.Батхшиг, ахмад ажилтан С.Наранцэцэг, номын санч А.Лхамханд нарын таван хүн, **Цэргийн хүндэт медалиар** Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн харуул, ахлагч Б.Энхтөгс, Зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн тасгийн дарга, хошууч С.Эрдэнэхишиг нарын 13 хүн, **Хөдөлмөрийн хүндэт медалиар** Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн слесарь Б.Энхбат, Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн жолооч Д.Энхтөр нарын дөрвөн хүн тус тус шагнагдлаа.

Энэ үеэр шагнал хүртсэн хүмүүст хандаж ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга, хошууч генерал Р.Сүхбат хэлсэн үгэндээ "Энэ жил Зэвсэгт хүчний түүхэнд шинэ хуудас нэмсэн олон үйл явдлаар дүүрэн байлаа. Энэ бол та бүхний эх орныхоо төлөө гэсэн хоёргүй, чин сэтгэлийн үр дүн юм. Зэвсэгт хүчнийхээ хөгжлийн түүхийг бүтээлцэж яваа та бүхэнд шинэ оны мэнд хүргэе" гэв. "Алтан гадас" одонгоор шагнагдсан Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн нягтлан бодогч Ж.Батхшиг "Хөдөлмөрийг минь үнэлж, төрийн дээд одон хүртээсэнд байрлалаа. Би Зэвсэгт хүчний ангиудын санхүүгийн албанд 36 дахь жилдээ ажиллаж байна. Тусалж, үргэлж урмын үгээр тэтгэж байдаг хамт олондоо баярлалаа" хэмээв.

## ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДАД БАЯР ХҮРГЭЛЭЭ

Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшин, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Амарсайхан нар өнгөрсөн оны 12 дугаар сард "Тавантолгой түлш" ХХК-д ажилласан. Энэ үеэр сайжруулсан түлш хүргэх

Зэвсэгт хүчний 013 дугаар ангид Нийслэлийн Засаг даргын Хөгжлийн бодлогын асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Ж.Батбаясгалан, Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, хурандаа Ж.Болдбаатар, "Тавантолгой түлш" ХХК-ийн



боломжгүй өндөрлөг цэгүүдэд түлш хүргэх ажлыг зохион байгуулах үүрэг, чиглэл өгсний дагуу өнгөрсөн сарын 23-ны өдрөөс эхлэн Зэвсэгт хүчний ангиудаас туулах чадвар сайтай 20гаруй(ЗИЛ-131)автомашинаар түлшний түгээлтийг хийж эхэлсэн. Өнөөдрийн байдлаар нийслэлийн өндөрлөг 25 цэгт машин явах боломжгүй, халтиргаа гулгаа ихтэй нөхцөл байдал бий болсон юм. Тиймээс тэдгээр өрх айл, хүүхэд, ахмад настнуудад гэрийнх нь гадаа түлш буулгах ажлыг цэргийн алба хаагчид гүйцэтгэж байна. Мөн сайжруулсан түлш савлах ажилд хугацаат цэргийн алба хаагчдыг дайчлан цалинтай ажиллуулж байгаа юм. Уг ажлын хүрээнд шинэ оны босгон дээр

гүйцэтгэх захирал М.Ганбаатар нар очиж нийслэлийг утаагүй болгоход оролцож байгаа хугацаат цэргийн алба хаагчдад баяр хүргэн, бэлэг гардууллаа. Нийслэлийн Засаг даргын Хөгжлийн бодлогын асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Ж.Батбаясгалан "Энхийн цагт эх орны хөгжил цэцэглэлт, бүтээн байгуулалтад үр дүнтэй оролцож болдог гэдгийг эрэлхэг дайчид та бүгд харуулж байна. Нийслэлээ цэвэр агаартай хот болгохын төлөө Зэвсэгт хүчний таван ангийн 300 гаруй цэргийн алба хаагчид санаачилгатай, идэвх зүтгэлтэй ажиллаж байгаа. Та бүгдээр эх орон, ээж, аав, ах дүү цаашлаад нийслэлчүүд бид бахархаж байна" хэмээн онцолсон юм.

## ЗХЖШ 2019 ОНД ХИЙСЭН АЖЛАА ТАЙЛАГНАВ



Зэвсэгт хүчний Жанжин штаб тайлангийн хурлаа оны өмнө хийж, 2019 онд хийж хэрэгжүүлсэн ажлаа дүгнэлээ. Тайлангийн хуралд Батлан хамгаалахын дэд сайд Т.Дуламдорж, ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг болон Зэвсэгт хүчний Жанжин штаб, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлал, Агаарын цэргийн командлалын бие бүрэлдэхүүн оролцлоо. Тайлангийн хурлаар ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга, хошууч генерал Р.Сүхбат ЗХЖШ-аас 2019 онд авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээг тайлагнаж, бие бүрэлдэхүүнтэй санал солилцов. Мөн Батлан хамгаалахын дэд сайд Т.Дуламдорж, ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг нар Зэвсэгт хүчний Жанжин штаб, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлал, Агаарын цэргийн командлалын бие бүрэлдэхүүнд хандан 2020 онд хэрэгжүүлж, шийдвэрлэх ажлуудыг хөндөж, холбогдох үүрэг, чиглэл өгөв. Тайлангийн хурлын төгсгөлд Зэвсэгт хүчний хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулан 2019 онд ажил үйлсээрээ манлайлсан анги, салбар, офицер, ахлагч, хугацаат цэргийн болон цэргийн гэрээт алба хаагч, ажилтнуудын шагналыг гардуулсан юм.

### Дугаарын сурвалжилга

Олимп, дэлхий, тивийн үе үеийн алдартнууд өсөн өндийсөн "Алдар" спорт хорооны ажлын нэг өдрийг сурвалжиллаа. Спорт хорооны дарга, хурандаа Г.Өсөхбаяр "Тамирчин хүн медалийн тавцанд зогсох хүртлээ ямар их хүч, хөдөлмөр, хөлс, зүтгэл гаргадгийг үгээр илэрхийлэхийн аргагүй. Эх орон, Зэвсэгт хүчнийхээ нэр хүндийг цуурайтуулж яваа тамирчид, тэдний ард чимээгүй атлаа уйгагүй хөдөлмөрлөдөг багш, дасгалжуулагчдыг маань

## "АЛДАР"-ААР ОВОГЛОСОН АЛДАРТНУУДЫН НЭГ ӨДӨР

сайн сурвалжилж өгөөрэй" гээд зарим спортын төрлийн бэлтгэлийн явцаас сонирхуулав. "Алдар"-ынхан чөлөөт бөх, жүдо, байт харваа, буудлага, дугуй, бокс, таеквондо, хүндийн өргөлт, сагс, үндэсний бөх, үндэсний сурын харваа, шагай, шатар, цана, тэшүүр, хөнгөн атлетик гээд спортын бүх төрлөөр тамирчдаа бэлтгэдэг бөгөөд төрөл тус бүртээ өөрийн гэсэн

танхим, амрах өрөөтэй юм байна. Нөгөөтэйгүүр сагсан бөмбөг, шагайн харваа, цана, тэшүүрээс бусад бүх спортын төрлөөр хүүхэд багачууд, өсвөр үеийнхэнд хичээллэх боломжийг бүрдүүлсэн нь нийтийн биеийн тамирт оруулж байгаа хэмжээлшгүй их хувь нэмэр гэлтэй.

(Үргэлжлэл нь V нүүрт)

# БАТЛАН ХАМГААЛАХЫН 2019 ОНЫ

## КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТӨВ НЭЭГДЭВ



Зэвсэгт хүчний тайван цагийн бүтцэд “Бүтээн байгуулалтын дэмжлэгийн газар”, “Кибер аюулгүй байдлын төв”-ийг Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор байгууллаа.

Улс орныг хөгжүүлэх бүтээн байгуулалтад оролцох үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хяналт тавих, мэргэжлийн удирдлагаар хангах нэгжийг бий болгож мөн Зэвсэгт хүчинд кибер аюулгүй байдлыг хангах тогтолцоог бүрдүүлээ. Цаашид барилга, инженерийн төрлийн цэрэг, кибер аюулгүй байдлын мэргэжлийн цэрэгтэй болох эрх зүйн суурийг тавилаа.

## БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙГ 2020-2050 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ ТОДОРХОЙ БОЛОВ



“Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого (2020-2050 он)” болон уг бодлогыг “2020-2025 онд хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөө”-нд тусгах Батлан хамгаалах, Зэвсэгт хүчнийг хөгжүүлж, бэхжүүлэх зорилго, зорилтуудыг тодорхойлов. Зорилт хэрэгжсэнээр 2050 он гэхэд Батлан хамгаалах тогтолцоо төгөлдөржих, Батлан хамгаалах аж үйлдвэрлэлийг хөгжүүлэн нэгдмэл тогтолцоотой, технологисон, өндөр чадамжтай Зэвсэгт хүчин болох ажлууд үе шаттай хийгдэнэ.

## “ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ” БАТЛАГДЛАА



Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт “Аймаг, нийслэл, сум, дүүрэг нь орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөтэй байна” гэж хуульчлан тогтоосны дагуу 21 аймаг болон Нийслэлийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, Цэргийн штабууд “Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө”-г боловсруулж, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд баталлаа.

Аймаг, нийслэлийн орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө батлагдсанаар тайван цагт орон нутгийн хамгаалалтын бэлтгэлийг хангах цогц арга хэмжээ хэрэгжиж эхлэх бөгөөд аймаг, нийслэлд орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжүүдийг байгуулж, тэдний удирдлага, бие бүрэлдэхүүний сургалт, дадлагыг тогтмол зохион байгуулж, орон нутгийн хамгаалалтын нөөцийг бүрдүүлж, онц болон дайны байдал үүссэн үед нутаг дэвсгэрийн зарчмаар орон нутгийн хамгаалалтыг зохион байгуулах нөхцөл, боломж бий болох юм.

Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарын “Цэргийн бэлтгэл” уламжлалт сургалтыг дээрх агуулгын хүрээнд бүсчлэн явуулж, зүүн бүсийн сургалтыг Дорнод, баруун бүсийн сургалтыг Баян-Өлгий, төвийн бүсийн сургалтыг Архангай, говийн бүсийн сургалтыг Баянхонгор аймагт тус тус зохион байгууллаа. “Цэргийн бэлтгэл” сургалтад 331 сумын Тамгын газрын дарга нараас 288 буюу 87 хувь нь хамрагдаад байна.

## АГААРЫН ЦЭРЭГ СУРГУУЛЬ-БАЙЛДАНЫ СӨНӨӨГЧ ОНГОЦТОЙ БОЛЛО



Монгол Улсын Зэвсэгт хүчний Агаарын цэрэг 1994 оноос хойш анх удаа сөнөөгч онгоцуудтай боллоо. Ингэснээр Монгол Улсын агаарын орон зай, агаарын хилийн халдашгүй дархан байдалд хяналт тавих, хамгаалах чадавх, боломж шинэ шатанд гарч байна.

## ХҮНД ДААЦЫН АВТО ЗАМЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛЛАА



Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулах Газрын тос боловсруулах үйлдвэрийн хүнд даацын 17,5 километр авто замын барилга угсралтын ажлыг анх удаа Зэвсэгт хүчин бие даан гүйцэтгэж улсын комисст хүлээлгэн өгснөөр байнгын ашиглалтад орууллаа. Мөн уг үйлдвэрийн 550 айлын барилгын ажлын гүйцэтгэгчээр Зэвсэгт хүчний анги томилогдон, үйл ажиллагаагаа эхлүүлээд байна.

## ТӨМӨР ЗАМЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖИЛД ...



“Төмөр замын бүтээн байгуулалтын ажилд Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник, хэрэгслийг оролцуулах тухай” Засгийн газрын шийдвэрийн дагуу Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг Зэвсэгт хүчний Жанжин штаб удирдан Зэвсэгт хүчний барилга, инженерийн цэргийн ангиудын бие бүрэлдэхүүн төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар амжилттай гүйцэтгэж байна.

Улс, бүс нутгийг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд Зэвсэгт хүчний анги, салбаруудыг оролцуулснаар барилга, инженерийн цэргийн чадавх, хүчин чадал бэхжин, барилга, инженерийн төрлийн цэрэг дахин сэргэх бодит суурь амжилттай тавигдлаа. Түүнчлэн бүтээн байгуулалтын ажилд оролцоноор Зэвсэгт хүчний офицер, ахлагч, цэргийн хугацаат болон гэрээт алба хаагчид төрөл бүрийн ажил, мэргэжилд суралцах, тэдгээрийн хөдөлмөрийн орлого нэмэгдэх, нийгмийн баталгаа сайжрах, улмаар нийгэмд ажил, мэргэжилтэй иргэдийг бэлтгэх төрийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд тодорхой хувь нэмэр оруулж байгаа юм.

## ХАЛХЫН ГОЛЫН БАЙЛДААНЫ ЯЛАЛТЫН 80 ЖИЛИЙН ОЙН АРГА ХЭМЖЭЭ БОЛОВ



Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 210 дугаар тогтоолоор батлагдсан төлөвлөгөөний дагуу Халхын голын байлдааны ялалтын 80 жилийн ойг Монгол Улсын эрх чөлөө, тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлыг хангахад жинтэй хувь нэмэр оруулсан дайчин баатруудаа нэхэн дурсах, алдаршуулах, өнөө үеийнхэнд тусгаар тогтнолын үнэ цэнийг таниулан ойлгуулах, эх оронч үзлийг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх агуулгын дор орон даяар амжилттай зохион байгууллаа. Ойн хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч, Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар “Халх гол-Шинэ сум” төслийн барилгын ажлыг Зэвсэгт хүчний 500 гаруй алба хаагчийн оролцоотойгоор 2019 оны 3 дугаар сараас 9 дүгээр сар хүртэлх хугацаанд зохих норм, стандартын дагуу чанартай гүйцэтгэж, Улсын комисст хүлээлгэн өгсөн юм.

Халхын голын байлдаанд оролцсон ахмад дайчдад нэг удаагийн буцалтгүй тусламж олгон, тэдэнд хүндэтгэл үзүүлсний зэрэгцээ Дорнод аймгийн Чойбалсан сумын нутагт байрлах Зөвлөлтийн дайчдын хөшөөг сэргээн засварлаж, “Мөнхийн гал” бадраалаа. Мөн тус ойн арга хэмжээний хүрээнд Оросын армийн “А.В.Александровын нэрэмжит Дуу бүжгийн эрдмийн чуулгын тоглолт” болон ОХУ-ын Агаар-сансрын хүчний уран нислэгийн “Русские Витязи” бүлгийн үзүүлбэрийг

нийслэл Улаанбаатар хотын иргэдэд үзүүлэх арга хэмжээг зохион байгууллаа.

Мөн хоёр улсын Зэвсэгт хүчний хамтарсан “Сэлэнгэ” тактикийн хээрийн сургуулийг Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн сургалтын төвд 2019 оны 8 дугаар сарын 15-28-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Тус сургуульд хоёр талаас 1500 гаруй цэргийн алба хаагч, 400 гаруй цэргийн зэвсэглэл, техник оролцсон юм.

## СУРАГЧДАД ЦЭРЭГ-ЭХ ОРОНЧ ҮЗЭЛ ХҮМҮҮЖИЛ ОЛГОХ СУРГАЛТ ЯВУУЛЖ ЭХЛЭВ



Засгийн газрын 2019 оны 200 дугаар тогтоолоор “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг баталлаа. Хөтөлбөрийн хүрээнд хийгдэж буй анхны том ажил болох улсын хэмжээнд ерөнхий боловсролын 802 дунд сургуулийн дунд, ахлах ангийн 266131 сурагчдын дунд улс орны хөгжилд хувь хүн бүрийн оролцоо чухал гэдгийг ойлгуулах, түүх, үндэстэн, эх орноороо бахархах, улс орныхоо тусгаар тогтнолыг дээдлэх үзэл төлөвшүүлэх сургалт, сурталчилгааг БСШУСЯ-тай хамтран өнгөрсөн оны 12 дугаар сараас Зэвсэгт хүчний алдартнууд, энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн албан хаагчдаар хийлгэж эхэлсэн нь хүүхэд залуучуудын сонирхолд нийцсэн үр дүнтэй ажил болж байна. Цаашид энэ арга хэмжээг орон нутагт зохион байгуулж иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх уламжлалт ажил болгоно.

## БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА ӨРГӨЖИВ



ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путины Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр “Монгол Улсад цэрэг-техникийн буцалтгүй тусламж үзүүлэх тухай” хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн үйлчлэлийг 2023 он дуустал сэргээх тухай Засгийн газар хоорондын протоколыг байгууллаа. Мөн БНХАУ-аас манай улсын Батлан хамгаалах салбарт буцалтгүй тусламж үзүүлэх протокол байгуулагдав. АНУ-ын Батлан хамгаалахын сайд Марк Эспер анхны гадаад айлчлалаа манай улсаас эхлүүлэв.

2019 онд Батлан хамгаалахын сайд Н.Энхболд Монгол Улстай стратегийн иж бүрэн болон стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлж буй орнууд, дэлхийн болон бүс нутгийн нөлөө бүхий орнуудын Батлан хамгаалахын сайд нартай уулзан цэрэг, цэрэг-техникийн хамтын ажиллагааг эрчимтэй өрнүүлсэн жил байлаа.

Монгол Улсын Батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа, бүс нутгийн аюулгүй байдлын чиглэлээр баримталж буй бодлого, үйл ажиллагааны талаар хамтын ажиллагаатай есөн улс, олон улсын нэг байгууллагатай Батлан хамгаалах яамд хоорондын зөвлөлдөх уулзалтуудыг амжилттай зохион байгууллаа.

## ХЗЦ-ИЙН КОМАНДАЛЫГ ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ ШИЛЖҮҮЛЭН БАЙРЛУУЛЛАА



“Төрийн цэргийн байгууллагын хөгжил-2030” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Хуурай замын цэргийн бие даасан байдал, үүрэг гүйцэтгэх чадавх, бэлэн байдлыг дээшлүүлэх зорилгоор Зэвсэгт хүчний ХЗЦ-ийн командлалыг Төв аймгийн Зуунмод сумын нутаг дэвсгэрт 2019 оны 11 дүгээр сард шилжүүлэн байрлууллаа.

# ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ, БҮТЭЭЛЧ АЖЛУУД

## ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДЫН НИЙГМИЙН АСУУДАЛ ШИЙДВЭРЛЭГДЭЖ БАЙНА



Зэвсэгт хүчний 016 дугаар бригадын албан тушаалын 91 айлын орон сууцыг хувьчлах асуудлыг Засгийн газраар шийдвэрлүүлснээр тус орон сууцанд амьдарч байгаа цэргийн тэтгэвэр, чөлөөнд гарагсад болон Зэвсэгт хүчинд одоо алба хааж буй зарим офицер, ахлагч, ажилтан албан хаагчид хувийн орон сууцтай боллоо.

Цаашид Төв аймгийн Зуунмод сумын нутаг дэвсгэрт ХЗЦ-ийн командлалын алба хаагчдын 30 айлын орон сууц ашиглалтад орох бөгөөд Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт баригдах "Ахлагч хотхон"-ны 360 айлын орон сууцны барилгын ажлыг ирэх онд эхлүүлэхээр бэлтгэлийг хангаад байна.

## ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ БАТЛАГДЛАА



"ҮБХИС-ийн хөгжлийн стратеги-2030" баримт бичгийг Батлан хамгаалахын сайдын тушаалаар батлав. Тус хөгжлийн стратеги батлагдсанаар улс орны

тогтвортой хөгжлийг болон аюулгүй байдлыг хангахад шаардлагатай батлан хамгаалах (цэргийн) чадавхыг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх боловсрол, эрдэм шинжилгээ, хүний хөгжлийн орчин үеийн цогц орчинг үе шаттайгаар хөгжүүлж, олон улсын нийтлэг жишигт нийцсэн судалгаанд суурилсан их сургууль болох нөхцөлийг бүрдүүлсэн онцлог үйл явдал боллоо.

## ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНИЙ ГАЗРЫГ ШИНЭЧЛЭН ТОГТООЛОО



Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага, салбарын байршил бүхий газрыг улсын тусгай хэрэгцээнд шинээр авах, хилийн зааг, талбайн хэмжээнд нь өөрчлөлт оруулах зэрэг асуудлыг Улсын Их Хурлын 2019 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн "Улсын батлан хамгаалах аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон тусгай хэрэгцээний газрын жагсаалт"-ыг батлууллаа.

## СУРГУУЛЬ, ДАДЛАГАД НИЙТ 6600 ОРЧИМ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИД ОРОЛЦОВ



Монгол Улсын Засгийн газрын шийдвэрийн дагуу 2019 онд Зэвсэгт хүчнээс энхийг дэмжих ажиллагаанд 5 цэргийн багт нийт 1300 орчим цэргийн алба хаагч, НҮБ-

ын энхийг сахиулах ажиллагаанд цэргийн ажиглагч, штабын болон холбогч офицероор 30 гаруй офицер, ахлагч тус тус үүрэг гүйцэтгэлээ.

2019 оны 3 дугаар сард Монгол Улсын Ерөнхий сайд тэргүүтэй төлөөлөгчид БНӨСУ-д хийсэн айлчлалын хүрээнд тус улсад явагдаж буй НҮБ-ын энхийг сахиулах "UNMISS" ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй Зэвсэгт хүчний цэргийн багийн үүрэг гүйцэтгэлт, үйл ажиллагаатай танилцлаа.

ОХУ-аас зохион байгуулдаг олон улсын "Цэргийн наадам"-д оролцдог тэмцээний төрөл, оролцогчдын тоог нэмэгдүүлснээс гадна тус наадмын нэг төрөл болох "Аравт" морин цэргийн олон улсын анхдугаар уралдааныг эх орондоо амжилттай зохион байгууллаа. Мөн "Торгоны зам" олон улсын авторалли тэмцээнд Зэвсэгт хүчний анги, байгууллага, алба хаагчид дэмжлэг үзүүлж, тэмцээнд оролцогчдоос өндөр үнэлгээ авлаа.

2019 онд Монгол Улсад 22, гадаад улсад 14 төрлийн хамтарсан цэргийн сургалт, дадлага явагдаж, үүнд ийм төрлийн сургалт, дадлагын түүхэнд хамгийн олон буюу давхардсан тоогоор манай 4600, гадаад орны 2000, нийт 6600 орчим цэргийн алба хаагчид оролцлоо.

## ХӨГЖИМЧИН ДАЙЧИД "ЗЭВСГЭЭ" ШИНЭЧИЛЛЭЭ



ЗХЖШ-ын Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжмийн хамт олон хөгжмийн зэмсгээ иж бүрэн шинэчилсэн амжилттайгаар "Цэргийн хөгжмийн 105 жилийн ой"-гоо угтлаа. Цэргийн сур хүчийг аялгуу эгшгээр илэрхийлдэг Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжмийнхний үеэ өнгөрөөсөн, он удаан жил шинэчлээгүй хөгжмийн зэмсгийг иж бүрэн шинэчлэв. Хөгжмийн зэмсгийн үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлэгч "Conn-Selmer" компанийн хамгийн сүүлийн үеийн хөгжмийн зэмсэгтэй болсон тус хамт олон эх орныхоо нэр хүнд, нүүр царай болж төрийн болон цэргийн бүх хүндэтгэлийн арга хэмжээ, гадаад, дотоодын уралдаан тэмцээнд нүүр бардам оролцохоор болж байна.

**БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ**

### Редакцын шууданд

#### 327 дугаар анги

\*Ангийн материал хангалт үйлчилгээний тасгийн угаагч, индүүдэгч Б.Сарангуад "Монголын марафон гүйлтийн холбоо"-ноос Монголын хэт холын марафон гүйлтийн олон улсын хэмжээний мастерын цол, зэргийг хүртээж, шилдэг тамирчнаар өргөмжлөв.

Мөн тус ангид ажиллаж байгаад чөлөөнд гарсан 80-аас дээш насны ахмад дайчдад шинэ жилийн баярыг тохиолдуулан өвлийн өвгөний



бэлэг гардуулж хүндэтгэл үзүүллээ.

\*Дорнод аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд цэрэг-эх оронч үзэл төлөвшүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг ангийн байрлалд зохион байгууллаа. Энэ үеэр НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа Монгол Улсын Зэвсэгт хүчний үүрэг, оролцооны талаар яриа хийж, урлагийн хэсэгчилсэн тоглолт, гардан тулааны үзүүлэх тоглолтыг сонирхуулан зэвсэглэл, техникийн үзэсгэлэнг дэлгэн үзүүлэв.

**Ахмад Н.МӨНХ-ОД**

#### 350 дугаар анги

Урлаг, спорт, ажил хөдөлмөрөөрөө бусдыгаа манлайлж хошуучилсан тэргүүний сайчуудаа тодрууллаа. "Хөдөлмөрийн аварга офицер"-оор ахмад Х.Ууганбаяр, "Хөдөлмөрийн аварга ахлагч"-аар ахлахаалагч Г.Түвшинжаргал, "Хөдөлмөрийн аварга ажилтан"-аар Б.Бямбацэцэг, "Тэргүүний хамт олон"-оор хоёрдугаар мотобуудлагын рот, "Шилдэг энхийг сахиулагч"-аар ахмад Ж.Энх-Орчлон, "Шилдэг эрэгтэй тамирчин"-аар дэд ахлагч Ө.Отгонбаяр, "Шилдэг эмэгтэй тамирчин"-аар дэд ахлагч С.Нандин-Эрдэнэ нар тодорлоо.

**М.БОЛОРТУЯА**

ЗАР

ЗАР

ЗАР

## МАГИСТРАНТУР, ДОКТОРАНТУРЫН СУРГАЛТАД ЭЛСЭЛТ АВНА

ҮБХИС-ийн 2019-2020 оны хичээлийн жилийн хоёрдугаар улиралд магистрантур, докторантурын сургалтад дараах хөтөлбөрөөр суралцагч элсүүлнэ. Үүнд:

### Магистрын хөтөлбөрт:

- 1.Цэрэг, захиргааны удирдлага;
- 2.Төрөл, тусгай мэргэжлийн цэргийн урлаг;
- 3.Артиллерийн зэвсэглэл;
- 4.Зенитийн пуужингийн зэвсэглэл;
- 5.Зенитийн артиллери-электроник;
- 6.Радио техник;
- 7.Цэргийн материал, техникийн хангалт;
- 8.Хуягт танкийн техник;
- 9.Цэргийн химийн техник, зэвсэг;
- 10.Цэргийн авто, гинжит машин;
- 11.Холбооны техник, хэрэгсэл;
- 12.Цэргийн удирдлагын автоматжуулалт;
- 13.Цэргийн зэвсэглэл;
- 14.Цэргийн инженерийн техник;
- 15.Цэргийн зам, гүүрийн инженер;
- 16.Цэргийн тусгай барилга байгууламж;
- 17.Цэргийн зэвсэглэл, техник судлал;
- 18.Байлдааны техник, зэвсгийн инженерчлэл;

инженерчлэл;

- 19.Цэргийн түүх судлал;
- 20.Аюулгүй байдал судлал;
- 21.Батлан хамгаалах судлал;
- 22.Зэвсэгт хүчний байгуулалт;
- 23.Цэргийн сэтгэл зүйн хангалт;
- 24.Цэргийн сургалт судлал;
- 25.Байлдааны хангалт;
- 26.Нийтийн удирдлага.

### Докторын хөтөлбөрт:

- 1.Батлан хамгаалах судлал;
- 2.Аюулгүй байдал судлал;

- 3.Дайн, цэргийн урлаг судлал;
- 4.Цэргийн удирдлага;
- 5.Дайны бус цэргийн ажиллагаа;
- 6.Цэргийн сургалт судлал;
- 7.Цэргийн түүх судлал;
- 8.Цэргийн зэвсэглэл, техник судлал;
- 9.Зэвсэгт хүчний байгуулалт.

Тус сургуулийн магистрын хөтөлбөрт элсэхээр бүртгүүлэгч нь бакалаврын зэрэг, докторын хөтөлбөрт элсэхээр бүртгүүлэгч нь магистрын зэрэг эзэмшсэн байна.

Магистр, докторын сургалтад элсэхийг хүсэгчид 2020 оны 1 дүгээр сарын 5-наас 2020 оны 1 дүгээр сарын 15-ны өдрүүдэд Хичээлийн I дүгээр байр, Ахисан түвшний сургалтын албаны 211 тоотод ирж бүртгүүлнэ үү.

Бүртгүүлэхээр ирэхдээ дараах бичиг баримтыг авч ирнэ. Үүнд:

- Иргэний үнэмлэх, хуулбарын хамт;
- Өргөдөл;
- Төрийн албан хаагчийн анкет;
- Магистрын хөтөлбөрт элсэгч нь бакалаврын диплом, хавсралтын эх хувийг нотариатаар баталгаажуулсан хуулбарын хамт, докторын хөтөлбөрт элсэгч нь бакалаврын болон магистрын диплом, хавсралтын эх хувийг нотариатаар баталгаажуулсан хуулбарын хамт;

- Цээж зураг 2 хувь;
- Бүртгэлийн хураамж 20000 төгрөг.

### Элсэлтийн шалгалт:

2020 оны 1 дүгээр сарын 16, 17-ны өдрүүдэд хичээлийн I байрны 208, 209 тоот өрөөнд 09.30 цагт эхэлнэ.

Шалгалтын нэгдсэн дүнг 2020 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр "www.mndu.gov.mn" сайтад байршуулна.

Доктор, магистрын хөтөлбөрт элсэхээр

### ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТЫН ХУВААРЬ

#### Магистрын хөтөлбөрт элсэгчдээс:

Д/д	Шалгалт авах чиглэл	Огноо	Цаг	Шалгалт авах хэлбэр	Шалгалт авах газар
1	Мэргэжил	2020.01.16	10.00-11.30	Бичгээр	210 тоот
2	Сэдвийн ярилцлага	2020.01.16	14.00-16.00	Сонгосон сэдвээр бэлдсэн танилцуулга	210 тоот
3	Нэгдсэн дүн	2020.01.23	14.00	www.mndu.gov.mn.	

#### Докторын хөтөлбөрт элсэгчдээс:

Д/д	Шалгалт авах чиглэл	Огноо	Цаг	Шалгалт авах хэлбэр	Шалгалт авах газар
1	Мэргэжил	2020.01.16	10.00-11.30	Бичгээр	209 тоот
2	Сэдвийн ярилцлага	2020.01.17	14.00-16.00	Сонгосон сэдвээр бэлдсэн танилцуулга	209 тоот
3	Нэгдсэн дүн	2020.01.23	14.00	www.mndu.gov.mn.	

бүртгүүлэгчдээс дараах шалгалтыг авна.

- Мэргэжлийн шалгалт
- Ярилцлага (Бүртгүүлэгч нь ярилцлагад орохдоо бүтээлийн жагсаалт, магистрын ажил, диссертац бичих сэдвийн танилцуулга, бүтцийн төлөвлөгөө авч ирнэ.)

**Харилцах утас:** 86100101, 99092890

**Цахим хаяг:** Ахисан түвшний сургалтын алба: www.mndu.gov.mn

**ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛЬ**

"Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр"-т Нийслэлийн ерөнхий боловсролын 124 сургуулийн дунд, ахлах ангийн 28238

сурагчийг хамруулсан нь хамрагдвал зохих сурагчдын 86,4 хувийг эзэлжээ. Сургалтын хоёр дахь шатанд зөвхөн аймгийн төвүүдийн ерөнхий боловсролын

170 орчим сургуулийн дунд, ахлах ангийн 24700 гаруй сурагчийг хамруулаад байна. Цаашид энэхүү хөтөлбөр 2024 оныг дуустал үргэлжилнэ.

## Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд: ХҮҮХЭД ЗАЛУУСТ ҮР ӨГӨӨЖТЭЙ, БОДИТОЙ АЖИЛ БОЛГОХЫН ТӨЛӨӨ ЗОРЬЖ БАЙНА



Өнгөрсөн онд Засгийн газрын тогтоолоор "Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр" батлагдсан. Энэхүү хөтөлбөрийг баталж хэрэгжүүлэх болсон хууль, эрх зүйн үндэслэлийн талаар ярилцлагаа эхлүүлэе.

-Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүний 2020 оны ажилд амжилт хүсье. Иргэд эх оронч үзэл, итгэл үнэмшилтэй, эх орон, тусгаар тогтнол, түүх, эх хэл, өв соёлоороо бахархах төлөвшилтэй байх нь манайх шиг цөөхүүлээ үндэстний хувьд нэн чухал дархлааны түвшинд хэрэгтэй. "Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс"-т "Бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт хүүхэд, залуучуудад цэрэг-эх оронч үзэл, хүмүүжил олгох хичээлийн хөтөлбөрийг тусгаж, хэрэгжүүлнэ", "Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого"-д "Бүх шатны сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүйд Монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, хувь хүний төлөвшил, хөгжил, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлийг тусган хэрэгжүүлнэ" гэж тус тус заасан. Нөгөө талаар иргэн бүр эх орноо хамгаалах бэлтгэлтэй байх үүргийг нь хуульчилсан. Эх орноо батлан хамгаалахад сургаж бэлтгэх, мөн эх оронч үзэл, хүмүүжлийг төлөвшүүлэх бодлого боловсруулах, хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор урган гарч байгаа юм. Иймээс Улсын Их Хурлаас "Батлан хамгаалах тухай", "Боловсролын тухай", "Бага, дунд боловсролын тухай", "Залуучуудын хөгжлийг дэмжих тухай" мөн "Монгол Улсын Засгийн газрын тухай" зэрэг хуульд дээрх асуудал тусгалаа олсон байдаг. Өнгөрсөн онд Засгийн газрын 200 дугаар тогтоолоор "Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр" батлагдлаа. Үүнийг үндэслэн "Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г өнгөрсөн оны 9 дүгээр сард Батлан хамгаалахын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдтай хамтран баталж бодит ажлуудыг эхлүүлээд байна.

### Тодорхой жишээ хэлнэ үү?

-Энэхүү хөтөлбөрийг хүүхэд, залуучуудад үр өгөөжтэй, бодитой ажил болгохын тулд "Ерөнхий боловсролын дунд сургуулиудын дунд, ахлах ангийн сурагчдад Зэвсэгт хүчний энхийг сахиулагч-цэргийн алба хаагчдаараа дамжуулан эх орон, тусгаар тогтнолын үнэ цэнийг ойлгуулах сургалт, сурталчилгааг зохион байгуулах гэсэн санаа, санаачилгыг маань Ё.Баатарбилэг сайд дэмжиж, хоёр яам хамтран энхий ээлжид Нийслэлийн сургуулиудад зохион байгуулсан.

Хоёр оны зааг дээр ерөнхий боловсролын сургуулиудын дунд, ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулсан энэхүү бүтээлч ажлын зорилгын талаар тодотгож өгнө үү?

-Энэхүү сургалтын зорилго нь сургагчдад улс орны хөгжилд хувь хүн бүрийн оролцоо чухал гэдгийг ойлгуулах, эх орон, монгол хүн болж төрснөөрөө бахархах, улс орныхоо тусгаар тогтнолыг дээдлэх үзлийг төлөвшүүлэхэд оршиж байсан юм. Зэвсэгт хүчний Жанжин штаб, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб болон Боловсролын газар, хэлтэстэй хамтран үндэсний хэмжээнд ерөнхий боловсролын сургуулиудын дунд, ахлах ангийн сурагчдад сургалт, үйл ажиллагааг 2019 оны 12 дугаар сарын 16-27-ны өдрүүдэд хоёр үе шаттайгаар зохион байгуулсан. Үүнд энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн Зэвсэгт хүчний 200 гаруй офицер, ахлагч оролцож яриа, танилцуулга хийсэн нь хүүхдүүд төдийгүй тэдний эцэг, эх, багш нарын талархлыг хүлээсэн маш сонирхолтой, үр өгөөжтэй ажил болсон. Сургуулийн захирлууд, Цэргийн штабын дарга нар уг арга хэмжээнд оролцож, Төрийн дууллаа эгшиглүүлэн Төрийн далбаагаа мандуулан хүндэтгэлтэйгээр эхлүүлж, энхийг сахиулагч-зочин багш нар "Монгол цэргийн түүх, уламжлал, энхийг сахиулах үйл ажиллагаан дахь Монгол Улсын Зэвсэгт хүчний үүрэг, оролцоо, ач холбогдол" сэдвээр лекц уншсан. Сургалтыг явуулахдаа энхийг сахиулагч-цэнхэр дуулгатуудын хувцас, өмсгөл, зэр зэвсэг, Өмнөд Судан, Афганистан, Чад, Сьерра Леон зэрэг улсын нөхцөл байдал, хүүхдүүдийн амьдрах, сурах орчинг Монгол

Улсынхаа хүүхдүүдийн амьдрах, сурах орчинтой харьцуулан гэрэл зураг, богино хэмжээний видео бичлэг ашиглан тайлбарласнаас гадна өөрт тохиолдсон бодит явдлыг ярьж, тухайн үед төрсөн сэтгэгдлээсээ хуваалцсан ба эх орон-эх оронч үзлийн талаар харилцан ярилцаж, тэдний асуултуудад хариулж байсан. Гол нь тэдгээр улсуудын нөхцөл байдал, сурч, амьдрах орчин, боломжийг нь өөрийн орныхтой харьцуулан ярилцаж байсан нь хүүхдүүдэд эргэцүүлэн бодох ухаарлыг өгч байгаа нь мэдрэгдсэн нь бидний хувьд чухал байсан юм. Хүүхдүүд маань энхийг сахиулагчдаас дайн дажинтай улс орон, дүрвэгсдийн хуаранд байгаа хүүхдүүдийн ахуй амьдрал, боловсрол, эх орноо санах, гэртээ ирэх үед төрсөн мэдрэмж, сэтгэгдэл, энхийг дэмжих ажиллагаанд оролцох шалгуур, зэвсэгт мөргөлдөөн болж буй улс орнуудын амьжиргаа, газар нутаг, цаг агаар, тэнд аж төрдөг хүүхдүүд, монгол хүүхдүүдийн ялгаа зэргийн талаар асуултуудыг хамгийн ихээр сонирхон асуусан байна лээ.

Тус хөтөлбөрийг хэрэгжүүлээд багагүй хугацаа өнгөрч байна. Сургалт, сурталчилгааны ажлыг хэрхэн зохион байгуулсан, түүнд хамрагдсан сургууль, хүүхдийн тоо чамлахааргүй байгаа байх. Та сургалтын үр дүн, ач холбогдлыг хэрхэн дүгнэж байна вэ?

-Сургалтыг богино хугацаанд, чанартай зохион байгуулахад анхааран ажиллаж, эхний үе шатанд Нийслэлийн ерөнхий боловсролын 124 сургуулийн дунд, ахлах ангийн 28238 сурагчийг хамруулсан нь хамрагдвал зохих сурагчдын 86,4 хувийг эзэлж байлаа. Сургалтын

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 200 дугаар тогтоолоор "Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг баталж, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Батлан хамгаалахын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны хамтарсан тушаалаар батлан амжилттай хэрэгжүүлээд байна. Тус хөтөлбөр хэрхэн биеллээ олж, ажил хэрэг болсон, үр дүн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг нартай ярилцлаа.

хоёрдугаар үе шатанд буюу 12 дугаар сарын 23-27-ны өдрүүдэд аймгуудын төвийн ерөнхий боловсролын 170 орчим сургуулийн дунд, ахлах ангийн 24700 гаруй сурагчийг хамруулан зохион байгууллаа. Аймаг, нийслэл, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, офицерууд, Зэвсэгт хүчний ангиудын энхийг сахиулагчид, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт болон Боловсролын хэлтсийн арга зүйчид, ерөнхий боловсролын сургуулиудын удирдлага, түүх-нийгмийн ухааны секцийн багш нар хамтран идэвх, санаачилгатай, маш сайн ажилласныг энд зориуд тэмдэглэж, баярласнаа илэрхийлэе. Түүнчлэн сургалтын талаарх мэдээллийг БХЯ, ЗХЖШ, Зэвсэгт хүчний анги, байгууллагууд, аймаг, нийслэл, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын вэб хуудас, олон нийтийн мэдээллийн сайтууд болон MNB, TB-5, NTV, UBS, ETV, MNC, TV6, SBN, ON-TV8, TV-25, TV-9, TM телевиз, "Соёмбо" сонин, "Дуулга" теле студи зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагуудаар сурталчилсан нь үр өгөөжтэй болсон гэж бодож байна. Энэхүү богино хугацааны үр дүнтэй сургалтад ерөнхий боловсролын 290 гаруй сургуулийн дунд, ахлах ангийн 52938 сурагчийг хамруулж, эх орон, тусгаар тогтнол, түүх, эх хэл, өв соёл, монгол хүн болж төрснөөрөө бахархаж, эх орноо хайрлахын үнэ цэнийг ухааруулсан ач холбогдолтой арга хэмжээ боллоо гэж дүгнэж байна.

Сургалтын явцад Баянгол дүүргийн 13 дугаар сургуулийн нэгэн сурагч "Эх орон гэдэг үг аман дээр байдаг хямдхан үг биш, сэтгэлд үлдэх үг" гэсэн бол Баянзүрх дүүргийн 53 дугаар сургуулийн нэгэн сурагч "Би том болоод Судан хүүхэд өргөн авч хүн байхын аз жаргалыг мэдрүүлнэ" гэж бичсэн байсан. Хүүхэд бүрийн сэтгэлд хүрсэн, эх оронч цэрэг эрсээрээ бахархсан, эх орноо хайрлах сэтгэлийг төлөвшүүлсэн цаг үеэ олсон ажил болжээ гэж дүгнэх үндэслэл байгаа биз.

Цаашид тус хөтөлбөр хэрхэн хэрэгжих вэ?

-Монгол цэргийн өдөр, орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 99 жилийн ой болон Энхийг сахиулагчдын өдрийг тэмдэглэх ажлын хүрээнд ерөнхий боловсролын сургуулиудын гуравдугаар улирлын хичээл эхлэхээр энэхүү ажлыг шинэ, илүү сонирхолтой арга хэлбэрээр дахин зохион байгуулахаар төлөвлөж байна. Мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтраад их, дээд сургуулиудын оюутнууд, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүд, техникийн коллежуудын сурагчдын дунд зохион байгуулах болно. Түүнчлэн бүх шатны боловсролын байгууллагуудын хичээлээс гадуур зохион байгуулах ажлын төлөвлөгөөнд тусгаж, жил бүрийн намар, хавар тодорхой үе шаттайгаар тогтмол зохион байгуулах нь зүйтэй. Гэхдээ дан ганц сургалтаар биш, хэвлэл мэдээллийн бүх хэрэгслээр тогтмол сурталчилж, иргэдийн оролцоо, идэвхийг өрнүүлэх нь бас үр дүнтэй гэж үзэж байгаа.

## Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг: ЭХ ОРОНЧ ҮЗЛИЙН ГАЛЫГ БАДРААЖ ӨГЛӨӨ

"Хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр" хэрхэн биеллээ олж, ажил хэрэг болсон талаар тодруулахгүй юу?

-Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам 2019 оныг "Иргэний ёс зүйн боловсролын жил" болгон зарлаж, энэ хүрээнд хүүхэд, залуусыг монгол хүн болгон төлөвшүүлэхэд чиглэсэн хоёр чухал ажлыг эхлүүлсэн. Юуны өмнө "Монгол ёс, хүмүүжил" хичээлийн хөтөлбөрийг шинэчлэн баталж, 1-5 дугаар ангид сурах бичгийг нь хангалттай тоогоор хэвлэж өглөө. Энэхүү хичээл хүүхдийг аав, ээж, ах заххаа хүндэлдэг, ахуй, соёлдоо ойрхон монгол хүн болон хүмүүжихэд дэм тусгаа өгнө. Нөгөө нь Батлан хамгаалах яамтай хамтран хэрэгжүүлж буй "Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр" юм. Дэлхий дахины хил хязгааргүй харилцаа, хэт хавтгай соёлын дунд монгол хүн монголоороо орших дархлааг буй болгоход энэхүү хөтөлбөр чиглэнэ.



-Яамдын хамтарсан ажлын хэсгээс хүргүүлсэн удирдамж, төлөвлөгөөний хүрээнд аймгууд өөр өөрийн онцлогтойгоор амжилттай зохион байгууллаа. Шинэ санаачилгууд ч энэ үеэр гарсан байна. Тухайлбал, Дорноговь аймаг Хилийн цэргийн булан байгуулж, Хил хамгаалах байгууллагын түүх, хилээс төрсөн баатруудаа сурагчдад танилцуулсан бол Төв аймаг "Эр цэргийн амьдрал, эх орны хүү" арга хэмжээг жил бүр зохион байгуулж, оны эцэст дүгнэж байхаар шийдвэрлэсэн байна. Зарим аймаг тус сургалтыг цаашид орон нутаг дахь цэргийн анги, салбарууд зохион байгуулах боломжтойг онцолсон байна лээ. Энэ бол маш том ажил болсны илрэл юм.

Тус хөтөлбөр цаашид хэрхэн үргэлжлэх талаар мэдээлэл өгөхгүй юу?

-Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх, улс орны хөгжилд хувь хүн бүрийн оролцоо чухал гэдгийг ойлгуулж, эх орноороо болон монгол хүн болж төрснөөрөө бахархах бахархлыг тээгч байх, улс орныхоо тусгаар тогтнолын баталгааг нэмэгдүүлж, түүх, соёл, шинжлэх ухааны давтагдашгүй үнэт өвийг үе дамжуулан үлдээх, байгалийн унаган төрхийг хадгалж, экологийн тэнцвэрт байдал болон тогтвортой хөгжлийг хангах зорилготой уг хөтөлбөр 2024 оныг дуустал хэрэгжинэ. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын болон Батлан хамгаалахын мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаалаар баталсан хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй. Үндсэн дөрвөн зорилтын хүрээнд 28 арга хэмжээг хэрэгжүүлэхээр заасан. Төлөвлөгөөний дагуу шат дараатай хэрэгжээд явна. Тухайлбал, "Цэрэг, эх оронч үзэл төлөвшүүлэх сургалт"-ыг сая зөвхөн ерөнхий боловсролын сургуулиудын дунд зохион байгууллаа. Цаашид мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, их, дээд сургуулийн оюутан, залуусын дунд хийхээр төлөвлөж байна.

Мэдээж, уг хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлсэн Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, тэр дундаа лекц уншсан энхийг сахиулагчдад хандаж хэлэх зүйл байгаа болов уу?

-Энэхүү арга хэмжээг хоёр яамны хамтарсан ажлын хэсгээс Гадна Зэвсэгт хүчний Жанжин штаб, Үндэсний батлан хамгаалахын их сургууль, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн хамт олон, нийслэл, дүүрэг, орон нутгийн удирдлага, Боловсрол, соёл урлагийн газар, Цэргийн штаб, ерөнхий боловсролын сургуулиудын хамтын зүтгэлээр амжилттай зохион байгууллаа. Сургалтыг хөтлөх гол ажлыг энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн туршлагатай, Зэвсэгт хүчний 180 гаруй офицер, ахлагч хийсэн. Эх орны эзэд болох олон мянган сурагч багачуудын сэтгэл зүрхэнд гал бадрааж, эх орноороо болон монгол хүн болж төрснөөрөө бахархах бахархлыг төрүүлээд ирсэн нийт офицер, ахлагч нартаа, зохион байгуулсан бүх хүнд талархал илэрхийлж байна. Эх оронч үзэл нь монгол хүн монгол хүнээ хүндэлж, бахархахаас эхлэнэ. Энэ үзлийг улам бүр бадрааж өглөө. Төслийг анх санаачилсан Батлан хамгаалахын сайд Н.Энхболд болон тус яамны удирдлагын багийн хамт олонд БСШУСЯ-ны нэрийн өмнөөс, мянга мянган сурагч багачууд, сурган хүмүүжүүлэгчдийг өмнөөс чин сэтгэлийн талархал илэрхийлэе.

Энэхүү хөтөлбөр нь анхны удаа маш олон хүүхдийг хамруулсан тухай ...

(Түрүүч нь 1 нүүрт)

ДУГААРЫН СУРВАЛЖИЛГА

# “АЛДАР”-ААР ОВОГЛОСОН АЛДАРТНУУДЫН НЭГ ӨДӨР

## ЯЛАЛТ, ЯЛАГДАЛ ХОЁРЫН ДУНД ЯВАХ ЁСТОЙ

Бидний эхний онцлох тамирчид нь МУГЖ, хошууч А.Гантулга ахлах дасгалжуулагчтай боксынхон. Боксынхон 12-14, 15-16, 17-18, 19-өөс дээш насны мэргэжлийн тамирчид гээд өдөрт дөрвөн өөр насныханд бэлтгэл, сургалтыг тус бүрт нь явуулдаг ажээ. Энэ цаг үед сурагчдын амралттай холбоотойгоор анхлан суралцаж байгаа болон өсвөрийн насны тамирчдын бэлтгэлийг хамтад нь явуулж байв. А.Гантулга багш “Миний хүүхдүүд ээ, та нар эрүүгээ дээш өргөөд байна. Эрүү дээшээ байх юм бол яг ингээд нам цохиулна” гээд өөрөө биеэрээ үзүүлээ. Баруун гартаа шүгэл, зүүн гартаа цагтай, өмссөн хувцас нь тэр чигтээ хөл болсон энэ дасгалжуулагчийг спортынхон андахгүй. Боксын ямар ч тэмцээн дээр “Алдар” гэсэн улаан цамцаар гоёчихсон явдаг түүний шавь болохоор олон хүүхэд “Алдар”-ыг зорьдог нь бэлтгэлийн танхимд байгаа олон боксчидоос тодорхой харагдаж байв. А.Гантулга хошууч “Алдар”-ын хаалгаар орж ирснээс хойш 30 гаруй жил тасралтгүй бэлтгэлийн танхимд шүгэл, цагтайгаа, медалийн тавцны ард баярын нулимс, бахархлын харцтайгаа яваа багш. Анх Х.Магван багшийн удирдлагад 1984 оноос хойш тамирчнаар гараагаа эхлүүлсэн гэнэ. “Олимпын гараа” гээд үе үеийн тамирчдыг бэлтгэдэг сайхан тэмцээнээс тамирчны гараагаа эхлүүлж, өдгөө олон шилдэг боксчидыг бэлтгэх их үйлсэд хүчин зүтгэж яваа нь энэ ажээ. Тэрээр тамирчдынхаа хажуугаар туслах багшаа ч бэлтгэж ирсний тод жишээ нь ОУХМ, ахлах дэслэгч Ж.Отгонбаяр. Ахлах дэслэгч Ж.Отгонбаяр багшийнхаа заавраар



хичээллэх боломжтой гэж онцлолоо. “Алдар”-ын боксчидоос тив, дэлхий, олимпын үе үеийн шилдэг тамирчид төрөн гарсан нь спортын түүхэнд хэдийнээ бичигджээ. Хамгийн ойрын жишээ гэхэд Нийслэлийн 79 дүгээр сургуулийн сурагч, 13 настай жаахан хүү А.Гантулга багшид шавь орж, 17-хон насандаа дэлхийн аваргаас мөнгөн медаль, 20 насандаа “Лондон-2016” олимпоос мөнгөн медаль хүртсэн нь гавьяат тамирчин Нямбаярын Төгсцогт.

Энэ жил боксынхны хамгийн том зорилго нь “Токио-2020” зуны олимпод оролцож, медаль хүртэх юм. А.Гантулга багшийн ярьснаар мэргэжлийн зургаан тамирчин ирэх 2 дугаар сард болох Азийн аварга, 5 дугаар сард Францад болох тэмцээнээс олимпын эрх авахаар төлөвлөсөн байна. Тэр дундаас Азийн аварга нь хамгийн боломжтой хувилбар бөгөөд тамирчид нь

долоон жил болж байна. Анх аав минь “Алдар”-ын хаалгаар хөтөлж оруулсан. Түүнээс хойш бэлтгэл, сургалтаа тасалж үзээгүй. Одоогоор үзүүлээд байгаа хамгийн том амжилт нь 2018 онд залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнээс хүртсэн хүрэл медаль. Хүн хичээвэл амжилт ойрхон байдгийг ойлгосон. Цаашдаа тив, дэлхийн хэмжээний тамирчин болох мөрөөдөлтэй” гэв. Тэрээр боксоор хичээллэснээр өдөрт дунджаар хоёр литр орчим хөлс гаргадаг, ханиад бараг хүрдэггүй, бие эрүүлжиг, чийрэгжсэн гэж нэмж онцлов.

Нийслэлийн 27 дугаар сургуулийн есдүгээр ангийн сурагч Б.Орчлон “Хичээллээд удаагүй байна, амжилт ч үзүүлж амжаагүй байгаа. Хоёр тэмцээнд орж, туршлагажсан. Багш маань “Тэмцээнд оролцож ялагдлаа гээд сэтгэлээр унаж болохгүй. Тамирчин хүн ялалт, ялагдлын дунд явах ёстой” гэж хэлсэн. Тийм болохоор хожигдлоо гээд сэтгэлээр унадаггүй. Ангийнхан маань эмэгтэй хүн боксоор хичээллэж болдог юм уу гээд их гайхдаг” гэлээ. Өсвөрийн боксын тамирчдын дунд цөөнгүй эмэгтэй хүүхдүүд байсны нэг нь Г.Бадмаараг. Тэрээр 2019 онд Ази тивийн залуучуудын аварга шалгаруулах тэмцээнээс хүрэл медаль хүртэж, спортын мастерын болзлоо хангасан гэнэ. “Бокс намайг тэсвэр тэвчээртэй болгож, асуудалд тайвнаар хандахад сургасан” гэхэд хажуугаас нь дасгалжуулагч, ахлах дэслэгч Ж.Отгонбаяр “Ямар ч спорт хүнийг тэсвэр тэвчээртэй болгож, ёс суртахуунтай иргэн болгож төлөвшүүлдэг” гэв.

Дасгалжуулагчдын нэг онцлог нь тамирчдын эцэг, эх, багш, сургуулийнхантай нь эргэх холбоотой ажилладаг оршдог. Эцэг, эхийн зөвлөл байгуулж, хүүхдүүдийн оролцох тэмцээн уралдаан, бэлтгэлийн явцын талаар байнга санал солилцон зөвлөлдөж явдаг хошууч А.Гантулга багш хэлж байсан юм.



өдөр бүрийн бэлтгэлийг зохион байгуулдаг аж. Түүнээс “Боксоор хичээллэхэд хамгийн чухал зүйл юу вэ” гэхэд “Нэгдүгээрт, сэтгэлзүй. Бокс бусад спортыг бодвол хүнд. Тэр утгаараа энэ спортоор тууштай хичээллэхийн тулд сэтгэл зүй бат тогтсон байх ёстой. Хүн харахад хоёр гараараа ээлжлэн цохиж, хамгаалж байгаа юм шиг атлаа бүгд өөрийн гэсэн дүрэм, техниктэй. Хөл, гарын тавилтаас эхлээд бүх зүйл шат дараатай” гэв. Мөн тэрээр боксоор 12 наснаас эхлээд

олимпын эрх өвөртлөөд ирнэ гэдэгт итгэл дүүрэн байгаагаа хэлж байсан юм. Мэдээж тэдний бэлтгэж ирсэн өсвөр болон мэргэжлийн тамирчдын үзүүлсэн амжилтыг тоочвол тун их. 2019 онд гэхэд Монголын хүүхдийн спортын зургаадугаар их наадам, залуучуудын аварга, улсын аварга, насанд хүрэгчдийн аваргаас эхлээд олон улсын уралдаан тэмцээнд “Алдар”-ын боксчид манлайлсан байна. Өсвөр үеийн зарим тамирчны сэтгэгдлээс хуваалцахад спортын мастер О.Тулга “Боксоор хичээллээд

## БАЙТ ХАРВААНЫХАН ОЛИМПЫН ЭРХЭЭ НЭМЭХ ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ

Ахлах дэслэгч Б.Ганзоригийн тэргүүлсэн байт харвааны тамирчид “Алдар”-ын бас нэг жигүүрт нь “тусгаар тогтножээ”. Байт харвааны танхимд ороход бүгд нам жим. Бокс, хүндийн өргөлт, чөлөөт бөхийнхөн шиг шуугиан тэнд өр үгүй юм. Зөвхөн сум нь байг онож буй чимээ л сонсогдоно. Энэ нь байт харваа гэдэг спорт оюун ухаанаа төвлөрүүлж хийдэгтэй холбоотой ажээ. Байт харвааныхан мөн л насны ангиллаар бэлтгэлээ явуулдаг бөгөөд сурагчийн амралттай холбогдуулан ойрноос нэг дор бэлтгэж байгаа гэнэ. Байт харваанд данстай мэргэжлийн 12 тамирчин, өсвөр үеэс мэргэжлийнх рүү орохоор бэлтгэгдэж байгаа 10 тамирчин байгааг Б.Ганзориг багш хамгийн эхэнд дурдлаа. Тэдний

600 доллар, мэргэжлийнх нь 3000 доллараас эхэлдэг. Авсан хойноо бол арчилгаа багатай. Манай суралцагч хүүхдүүдийн олонх нь өөрсдийнхөө зардлаар нум, сумаа авчихдаг” гэлээ. Гэхдээ нум, сумыг гурван жил болоод шинэчлэх шаардлагатай болдог гэнэ. Энэ нь харвалт муудаа, таталт сулардагтай холбоотой аж. Байт харвааныханд аюулгүй байдалтай холбоотой бичигдээгүй нэг дүрэм үйлчилдэг нь тамирчид зэрэг харваж, зэрэг сумандаа явдаг хатуу дэг ажээ. Байт харваагаар хичээллэсэн хүүхэд цөх нуруутай, өндөр болдог байна. Сунгалтын дасгалыг бэлтгэлийн өмнө заавал хийж хэвшсэн нь хувь хүний өсөлтөд нь нөлөөлдөг байна. Зарим мэргэжлийн болон өсвөрийн тамирчид ийн ярилаа.



тамирчдыг энэ жил 15 уралдаан тэмцээн хүлээж байгаа гэнэ. Жилд дунджаар дотооддоо 12-15 тэмцээн зохион байгуулагддаг агаад тэндээс амжилт үзүүлсэн тамирчдаа олон улсын уралдаанд явуулдаг аж. Байт харваанынхаас одоогоор олимпын эрх авсан тамирчин нь ОУХМ, дэд ахлагч Б.Отгонболд. Цаашдаа олимпын эрхтэй тамирчдынхаа тоог багийн төрөлд нэмэгдүүлэх зорилго тавьсан, ирэх 6 дугаар сард ХБНГУ-д явагдах тоглолтоос бүх зүйл шалтгаалах аж. Гэхдээ шийдвэр нь шигшээ багийнхнаас хамаарах гэнэ. Ахлах дэслэгч Б.Ганзориг нь “Алдар”-т 1998 оноос байт харвааны тамирчнаар ажлын гараагаа эхэлж, 2009 онд багш, ОУХМ Н.Даариймаагийнхаа залгамжийг авч, ахлах дасгалжуулагчаар ажиллаж байгаа юм байна. “Алдар”-ын байт харвааны түүхийн цадиг 1961 оноос эргэсэн тухай ч тэр бас хэлэв. 1961 онд зохиогдсон анхдугаар спартакиадад “Алдар” нийгэмлэгийн тамирчин Ж.Мөнх-Очир түрүүлж, Зэвсэгт хүчний байт харвааны спортын анхдагч аваргаар тодорсон замнал өнөөдөр ч тасраагүй хэвээрээ байна. Байт харвааны гол багаж хэрэгсэл болох нум, сумын хувьд харьцангуй үнэтэй байдаг талаар сонссоноо лавлахад ахлах дасгалжуулагч “Хүүхдүүдийн болон мэргэжлийн тамирчдын нум хоорондоо асар их зөрүүтэй. Хүүхдүүдийнх 400-

ОУХМ, дэд ахлагч Н.Ариунбилэг “2009 оноос хойш 11 жил тасралтгүй хичээллэж байна. Энэ спорт надад олон сайхан зүйлийг бэлэглэсэн. Хамгийн түрүүнд тэсвэр тэвчээрийг бэлэглэж, амьдралын нугачаанд бүдрэхгүй байх сэтгэл зүйг минь бэлтгэж өгсөн. Хоёрдугаарт, эрүүл мэнд. Байт харваа гэлтгүй бүх спорт л хүнийг эрүүл чийрэг байлгаж чаддаг. Багш маань бидний төлөө маш их хөдөлмөрлөдөг дөө” гэв. Дэд ахлагч Н.Ариунбилэг нь байт харвааны шилдэг тамирчдын нэг бөгөөд тив, дэлхийн 10 орчим тэмцээнээс алт, мөнгө, хүрэл медаль хүртсэн амжилтыг үзүүлжээ.



Спортын мастер П.Мишээлт, Э.Батбилэг болон Т.Билгүүн гээд олон залуус байт харваагаар хичээллээд удаж байгаа, багш маань та нар дор хаяж 4-5 жил хичээллэж байж, энэ спортын дөртэй болно шүү гэж хэлдэг гэгцгээв. Харин анхлан суралцаж байгаа 6-11 дүгээр ангийн сурагчид болох Н.Энхжин, Б.Төгстөгөлдөр, Э.Ариунзаяа, Ч.Энхмарал, С.Орчлон, Ө.Баярчулуун, М.Нарансолонго нар байт харваагаар хичээллэж байгаадаа баяртай байгаа, ар гэрийнхэн их дэмждэг, багш маань бидний төлөө байнга “үглэдэг”, гэхдээ загнадаггүй, ирээдүүд шилдэг тамирчин болох мөрөөдөлтэй гэдгээ хэлж байсан юм.

## ЧӨЛӨӨТИЙНХӨН ШИНЭ ОНЫГ АМЖИЛТ ДҮҮРЭН ЭХЛҮҮЛЭВ

Монгол Улсын гавьяат дасгалжуулагч Ц.Хосбаяр багшийн хэдэн шавь 2020 оныг тун одтой эхлүүлээ. Нэгдүгээр сарын 3-6-ны өдрүүдэд Спортын төв ордонд болсон Чөлөөт бөхийн 2020 оны насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 40 гаруй тамирчин хурд хүч, бяр чадлаа сорин өрсөлдсөнөөс 30 гаруй нь шигшээд үлдэж, үүнээс 21 тамирчин нь алт, мөнгө, хүрэл медалийн эзэд болжээ. Тухайлбал, эрэгтэйчүүдээс ахмад Г.Мандахнаран, О.Уйтүмэн нар алт, С.Билгүүн, Г.Бэгзжав нар мөнгө, Б.Даваабанди, Б.Батмагнай, Г.Ханбүргэд,



Б.Бямбадорж, Г.Даянбилэг нар хүрэл медаль хүртсэн байна. Эмэгтэйчүүдээс ахлах ахлагч С.Цэрэнчимэд, Э.Цэвэгмэд нар алт, ахмад Б.Одончимэг, Б.Мөнхнар, Г.Отгонжаргал, Б.Майцэцэг, П.Номин-Эрдэнэ нар мөнгө, А.Наранцацрал, Б.Отгонтуяа, П.Шинэхүү, Т.Цэнд-Аюуш, Г.Ариунжаргал нар тус бүрийнхээ жинд хүрэл медаль хүртэж, “Алдар”-ын амжилтыг буухиалжээ. Гавьяат дасгалжуулагчаас сэтгэгдлийг нь хуваалцахад “Үнэхээр сайхан байна. Миний хүүхдүүд маш том амжилт үзүүлээ. Тэмцээний үеэр олон хүн хэдэн шавь нарын минь төлөө гүйлээ. Тэр хүмүүст маш их баярлалаа. Миний тооцолгож байгаагаар 2013-2020 он хүртэлх хугацаанд “Алдар”-ын чөлөөтийнхөн 2015 оноос бусад үед багаараа аваргалсан. Одоо миний хэдэн хүүхдүүдийг олимпын эрх авах цөөнгүй тэмцээн хүлээж байна. Авна гэдэгт маш их итгэлтэй байгаа. Энэ нь шинэ оны анхны тэмцээнээс маш тодорхой харагдаж байна. Шигшээ багийнхан үүнд шударга хандаасай билээ” гэсэн юм. Нийгмийн сүлжээнд ч Хосоо багшийг магтаж, бишрсэн сэтгэгдлүүд дүүрэн байв. Уралдааны үеэр түүний л шавь нар алт, хүрэлийн төлөө хоорондоо барилдаж, багш нь хэдэн тамирчдынхаа дунд толгойгоо “эргэтэл” амьсгаа өндөр гүйж явсан талаар олон сэтгүүлчид бахдан бичсэн байлаа.

Чөлөөтийнхөнд амжилтын хажуугаар сайн мэдээ ч байна. Учир нь 2018 оноос хойш хамтарсан бэлтгэл хийж байгаа БНСУ-ын чөлөөт бөхийн шигшээ багаас чөлөөт бөхийн иж бүрэн хоёр дэвжээ ирүүлсэн байна. Багш шавь нартайгаа шинэ дэвжээгээр тойрч гүйгээд, хурандаа Г.Өсөхбаяр тэднийг дагаж байдагаараа инээчихсэн алхаж байгааг нь харсаар “Алдар”-ын сурвалжилгаа төгсгөв өө.

Дэслэгч Д.БОЛОРМАА

## ХҮНДИЙН ӨРГӨЛТӨӨР ЭМЭГТЭЙЧҮҮД ИХЭЭР ХИЧЭЭЛЛЭДЭГ АЖЭЭ



Хүндийн өргөлтийнхний танхимаар орлоо. Ахлах дасгалжуулагчаар ОУХМ А.Отгонжаргал, туслах дасгалжуулагчаар дэслэгч Ч.Март гэдэг гэр бүлийн хоёр хүн ажилладаг юм байна. Хоёулаа л хүндийн өргөлтийн спортод залуу насаа зориулж яваа ажээ. Хүндийн өргөлтөд мэргэжлийн 10 орчим тамирчин хамаардаг бөгөөд мөн л өсвөр үеийнхнийг энэ спортоор хичээллэхэд нь тусалдаг байна. Хүндийн өргөлтийнхөн 2019 онд Нийслэлийн хүндийн өргөлтийн аварга шалгаруулах тэмцээнээс алт 27, мөнгө 12, хүрэл 9, Азийн аварга шалгаруулах тэмцээнээс нэг мөнгө, хоёр хүрэл, Дэлхийн

аварга шалгаруулах тэмцээнээс нэг хүрэл, “Дэлхийн цом”-оос нэг алтан медаль авсан амжилт үзүүлжээ. Өнгөрсөн оны төгсгөлд зохион байгуулагдсан Монголын хүүхдийн спортын зургаадугаар их наадмаас ч мөн адил өсвөрийн тамирчид нь дөрвөн алт, дөрвөн мөнгө, таван хүрэл медаль хүртэж, олон ч төрөлд рекордыг шинэчилсэн байна. Мэдээж “Дэлхийн цом”-ын эзэн дэслэгч М.Анхцэцэг энэ л танхимд бэлтгэл сургуулилтаа хийдэг бөгөөд энэ цаг үед эзгүй байв. Харин түүний хамгийн бага дүү М.Эрдэнэбат өнгөрсөн оноос хичээлийнхээ хажуугаар бэлтгэл сургалт хийдэг болсон гэнэ. Түүн шиг удам дамжсан тамирчид

цөөнгүй байсан нь М.Ганбаатарын хүү спортын мастер Г.Өнөболд. Түүний аав хүндийн өргөлтийн нэгэн цаг үеийн шилдэг тамирчин агаад аавынхаа сонирхлыг үргэлжлүүлж байгаа хүү нь өсвөр үеийн гурван удаагийн аварга, залуучуудын улсын аваргад гурван удаа түрүүлж, насанд хүрэгчдийн аваргад мөн гурван удаа түрүүлсэн шилдэг тамирчин ажээ. Энэ жил хүндийн өргөлтийнхнийг олон уралдаан тэмцээн хүлээж байгаа гэнэ. Хамгийн эхнийх нь энэ сарын 11-ний өдөр болох Насанд хүрэгчдийн улсын аварга гэдгийг дасгалжуулагч Ч.Март хэлэв. Тэрээр хүн бүр мундаг тамирчин болох албагүй. Гэхдээ нийгэмдээ хэрэгтэй, хатуужилтай, эрүүл саруул монгол хүн энэ заалнаас төрөх ёстой гээд нэгэн жишээ татан ярих. Наранчулуун гэдэг ахмад тамирчин тэтгэвэртээ гарснаас хойш бие нь ихэд өвдөх болж, бүр таяганд оржээ. Ахмадаа танхимдаа ирж, бэлтгэл хийхийг хурандаа Г.Өсөхбаярыг зөвлөхөд итгэл муутай ирсэн ч удалгүй эрүүл болоод таягаа хаяад гарсан гэнэ.

Дашрамд өгүүлэхэд тамирчдын олонх нь эмэгтэйчүүд байв. Үүнийг дасгалжуулагч нь “Хүчний спортоор манай эмэгтэй тамирчид амжилт их үзүүлж байгаа. Тэр хэмжээгээр элсэлт их орж ирдэг болсон” гэсэн юм.

# ГАЛТ ЗЭВСГИЙН СУМНЫ ХЭРЭГЦЭЭ, ҮЙЛДВЭРЛЭХ БОЛОМЖ

**Бэлтгэл хурандаа Б.ХАДБААТАР**  
/Техникийн шинжлэх ухааны  
магистр, УБХИС-ийн докторант.  
Пиротехникийн хэрэгслийн  
Зөвлөх инженер/

## 1. Шаардлага

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс" баримт бичигт "Монгол Улсын батлан хамгаалах тогтолцооны үндэс нь төр, захиргааны байгууллагууд, нийт иргэний оролцоонд тулгуурласан орон нутгийн хамгаалалт, мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчин, нэгдмэл удирдлага, төлөвлөлт бүхий дайчилгаа болно" хэмээн заасан байдаг.

"Орон нутгийн хамгаалалтын тухай" хуульд заасны дагуу иргэд, аж ахуйн нэгжийн гар дээр байгаа галт зэвсэг нь орон нутгийн батлан хамгаалах нөөцийн нэгэн хэсэг болохоос гадна хуулийн дагуу эдгээр галт зэвсгийг даалгаваржуулж, орон нутгийн хамгаалалтын нэгжид ашиглах, холбогдох сургалтыг зохион байгуулах ёстой.

Орон нутгийн хамгаалалтын сургалт нь Монгол Улсын хэмжээнд бүх аймаг, сум, нийслэл, дүүрэгт төлөвлөгөөний дагуу тодорхой үе шаттайгаар давтагдан явагдах тул сургалтад ашиглах спорт-ангийн зориулалтын галт зэвсгийн сумны нөөцийг бүрдүүлэх шаардлага зайлшгүй урган гарч байна. Энэхүү сургалтыг орон нутгийн батлан хамгаалах тусгайлан чиг үүрэг бүхий анги, байгууллагууд зохион байгуулах үүрэгтэй. Харин галын бэлтгэлийн сургалт, харуул хамгаалалтын буудлагын бэлтгэлийг буудлагын спортын холбоод зохион байгуулах бүрэн боломжтой.

Монгол Улс буудлагын спортын олон жилийн уламжлалтай бөгөөд олимпын төрөлд хамаарах спорт гар бууны төрлөөр тив, дэлхийн аваргуудтай, олимпын тоглолтоос мөнгө болон хүрэл медаль хүртэж байсан. Буудлагын спортоор гаргасан амжилтыг харахад ихэвчлэн бага калибрын буюу өртөг хямд, олдоц ихтэй 5,6x15 мм-ийн сумаар буюу бидний хэлж заншсанаар калибрын сумаар бууддаг зэвсгээр үзүүлсэн амжилтууд байна. Харин буудлагын спортын бусад төрлүүд хөгжөөгүй, амжилт гаргахгүй байгаа гол шалтгаан нь тухайн төрлийн буудлаганд хэрэглэдэг чанартай буу, сум ховор, өртөг өндөр байдагтай холбоотой.

Тухайлбал, тусгай албадын галын бэлтгэл болон хөдөлгөөнт буудлагын спорт зэрэгт дунд калибрын сум их хэмжээгээр хэрэглэгддэг. Харамсалтай нь эдгээр калибрын сум нь зөвхөн импортоор орж ирдэг, мөн хөрш орнуудын тавьсан хоргоос хамаарч сумыг зөвхөн агаараар тээвэрлэдэг зэргээс шалтгаалан сумны өртөг дэлхийн дунджаас даруй 2,5-5 дахин их байгаа нь манай орны буудлагын спортын амжилт, сургалтын чанарт сөргөөр нөлөөлж байна.

Зэвсэгт хүчин, Хилийн цэргийн зэвсэглэлд байгаа автомат буу, гар бууны галын бэлтгэл хичээлд ашиглаж буй байлдааны зориулалтын ган зүрхэвчтэй 7,62x39 мм, 9x18 мм-ийн калибрын сумны оронд спортын зориулалтын гуулин бүрээс, тугалган зүрхэвч бүхий "FMJ" хошуутай сумыг ашиглаж эхэлбэл байлдааны бууны гол төмрийн элэгдлийг багасган ашиглалтын хугацааг уртасгах, сургалтад зарцуулах сумны тоог ихэсгэж байлдааны бэлтгэл сургалтыг илүү чанартай, үр дүнтэй явуулж, байлдааны нөөцийг бууруулахгүй байх боломж бүрдэх юм.

Дээрх хэрэгцээ, шаардлагын улмаас эх орондоо галт зэвсгийн сумны үйлдвэр, нэн тэргүүнд спортын зориулалтын сум угсрах үйлдвэр байгуулах нь эдийн засгийн болоод бусад олон талын ашиг тустай болно.

## 2. Галт зэвсгийн сумны ерөнхий ангилал

Буудлагын зэвсгийн буюу галт зэвсгийн сумыг зориулалт, бэлтгэх арга, зохион бүтэц, асаах хэрэгслийн байрлал, ашиглаж буй бууны гол төмрийн төрлийг

харгалзан үзэж дараах байдлаар ангилна:

### Зориулалтаар нь:

- байлдааны;
- спорт-ангийн (эсвэл иргэний гэж хэлнэ);

### Бэлтгэх аргаар нь:

- албаны;
- тусгай зориулалтын.

### Бэлтгэх аргаар нь:

- гар хийцийн;
- угсралтын жижиг

үйлдвэрлэлийн;

- иж бүрэн цогц үйлдвэрийн.

### Асаах хэрэгслийн

байрлалаар нь:

- цагирган асалттай (эсвэл цагирган галтай, захын галтай гэж хэлж болно);

- төвийн асалттай (эсвэл төвийн галтай гэж хэлж болно).

### Ашиглаж буй бууны гол

төмрийн сувгийн төрлөөр нь:

- бянтат бууны;
- гөлгөр гол төмөрт бууны;
- хосолмол гол төмөрт галт зэвсгийн.

Байлдааны зориулалтын сум нь амьд хүчийг устгах, шархдуулан жагсаалаас гаргах, хөнгөн хуягласан зэвсэглэл, техникийг сөнөөх, амархан авалцах хий шингэнийг шатаах зэрэг тусгай үүргийг гүйцэтгэх шаардлагатай тул сумны хошуунд ган зүрхэвч, шатаах, дэлбэлэх, гэрэлт мөр гаргагч зэрэг ажиллагаатай элементүүдийг суулгаж өгсөн байдгаараа спортын болон ангийн сумныхаас ялгардаг. (Зураг-1. Байлдааны ган зүрхэвчтэй сумны бүтэц)

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1

Зураг-1



Зураг-3

сум гэж ангилан ялгаж нь илүү тохиромжтой болоод байна.

Ангийн болон спортын бууны сумыг дэлхий нийтэд тогтсон нэрлэмжээр нэрлэж бичих, харгалзах тэмдэглэгээтэй болоод удаж байна. Эдгээрээс спортын буудлага, албаны буудлагад хамгийн тохиромжтой, үйлдвэрлэхэд хялбар сумны зарим хошуутай танилцъя. (Зураг-4. Спортын буудлагад ашиглаж байгаа зарим сум)

### FMJ-Full Metal Jacket:

бүрэн металл бүрээстэй хошуу гэж орчуулж болно. Энэ хошуу нь спортын буудлаганд ч, ан агнуурт ч мөн адил тохирно. Энэ бол зөөлөн металаар хийсэн (мельхиор-зэс болон никелийн, зарим тохиолдолд төмөр ба марганец нэмсэн хайлш, том пак-зэсийн агууламж 88-97%, цайрын агууламж 10% эзэлдэг нэгэн төрлийн гууль, биметалл-хоёр эсвэл түүнээс олон төрлийн металлын давхаргаас бүрдэх давтамл материал) бүрээс, хар тугалган зүрхэвч бүхий хошуу юм.

Хошууны үзүүрийг нүхлээгүй, зүрхэвч нь бүрээснээс дээш илүү гараагүй, сонгодог шувтан хэлбэртэй байдаг.

### HPBT-Hollow Point Boat

Tail: Үзүүр хэсэг хөндий, шувтан төгсгөлт бүрээстэй сум. Цул тугалган зүрхэвчтэй, гадуураа гуулин бүрээстэй. Үзүүрийн хөндий ба шувтан төгсгөл агаарын хуйлралын нөлөөг тогтвортой болгон цэцийг нэмэгдүүлдэг.

### 3. Сумны үйлдвэрлэлийн талаар

Аливаа улс орон сумны хэрэгцээг өөрсдөө үйлдвэрлэн бий болгохыг хичээдэг. Энэ нь тухайн улсын батлан хамгаалах хүчин чадлын нэг чухал хэсэг болдог. Сумны үйлдвэрлэл бий болсноор олон зуун жил болж байгаа ба үйлдвэрлэлийг нутагшуулахад бэрхшээл бага, хэт өндөр технологийн шаардлага байхгүй. Дэлхийн олон улс орнууд хэрэгцээ, шаардлагаас хамаарч дараах төрлийн сумны үйлдвэрийг явуулж байна. Үүнд:

- Гар хийцийн дахин угсралтын өрхийн үйлдвэрлэл;
- Угсралтын жижиг үйлдвэрлэл;
- Иж бүрэн цогц үйлдвэр гэсэн ерөнхий ангилалтай.

Гар хийцийн дахин угсралт нь тухайн хүн шахах, бөгжлөх, жинлэх зэрэг энгийн хийцийн гар ажиллагаат багажийг ашиглан зориулалтын зөвшөөрөлтэй газраас худалдан авсан хонгио, бялт, хошуу, дарийг угсарч, худалдан борлуулах зорилгогүй зөвхөн өөрийн хэрэгцээнд зориулан сум хийж гар ажиллагаа юм. Сумыг гар аргаар угсрахад чанарын хяналт тавих, аюулгүй ажиллагааны стандартыг мөрдөх зэрэг үйлдвэрлэлийн өндөр шаардлага тавигдахгүй. Тэгдээ бүтээж бага, цөөн тоогоор хийгдэх тул нэг бүрийн өртөг өндөр болдог.

### Монгол Улсын "Галт зэвсгийн тухай" хуулийн дагуу


иргэн хүн гар аргаар сум угсарч, өрхийн үйлдвэрлэл явуулах хориотой тул энэ үйлдвэрлэлийг явуулах боломж бүрдээгүй байна.

Угсралтын жижиг үйлдвэрлэл нь сумны зарим хэсгүүдийг худалдан авч стандартын дагуу хийгдсэн

механик болон автомат ажиллагаатай бага оврын тоног төхөөрөмжүүд ашиглан тухайн сумны баллистикийн шаардлага хангасан, стандартад нийцсэн бүтээгдэхүүнийг угсарч, батлагдсан стандартын дагуу үйлдвэрлэх ажиллагаа юм. Иж бүрэн үйлдвэртэй харьцуулахад үйлдвэрлэлийн бүтээж багавтар боловч өндөр чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой. Тоног төхөөрөмжүүд нь энгийн, овор хэмжээ бага, хэрэгцээнээс хамаарсан технологийн өөрчлөлтийг хурдан хийх боломжтой тул тухайн хэрэглэгчийн захиалгаар олон төрлийн сумыг үйлдвэрлэх боломжтой.

"Галт зэвсгийн тухай" хуулийн дагуу Монгол Улсад спортын зориулалтын сум угсрах жижиг үйлдвэрлэлийг явуулах эрх зүйн бүрэн боломжтой байна.

Иж бүрэн цогц үйлдвэрлэлээр сумны хонгио, хошуу, дарь, бялт зэрэг үндсэн хэсгүүдийг үйлдвэрлэн угсарч савладаг. Ихэвчлэн тухайн улсын батлан хамгаалах хэрэгцээний байлдааны зориулалтын сумыг маш олон тоогоор хямд өртгөөр үйлдвэрлэн гаргах зорилготой.



Зураг-4

Хямд өртгөөр хийх ганц боломж нь сумны бүтцийн хэсэг бүрийг үйлдвэрлэн угсардагт байдаг. Үйлдвэрлэн технологийн дамжлага олон төрлийн, тоног төхөөрөмжүүд нарийн бүтэцтэй, том овортой, өндөр үнэтэй байна. Байлдааны сум нь хадгалалтын хугацаа урт, тээвэрлэхэд аюулгүй, бөх бат байх ёстой тул сав, баглаа боодлод өндөр шаардлага тавигдана. Байлдааны суманд өндөр цэцтэй байх шаардлага тавигдахгүй боловч найдвартай ажиллагааг чухалчилдаг ба тухайн улсын байлдааны сумны стандартын дагуу үйлдвэрлэдэг.

"Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс" баримт бичиг, 2016 онд батлагдсан "Монгол Улсын батлан хамгаалах тухай" хуульд "байлдааны зэвсэг, техник, материал хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, цэргийн зориулалттай зэвсэг, сум, галт хэрэглэл үйлдвэрлэх бодлого боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах" хэмээн заасан тул байлдааны зориулалтын сум үйлдвэрлэх боломж бүрдсэн байна.

Угсралтын жижиг үйлдвэр нь тоног төхөөрөмжийн онцлог болон үйлдвэрлэлийн бүтээмжээс шалтгаалан нарийн төвөгтэй бүтэцтэй, үнэ хямд, цэргийн зориулалтын сум үйлдвэрлэх боломжгүй бол улсын иж бүрэн цогц үйлдвэр нь том бүтэцтэй, технологийг богино хугацаанд өөрчлөх уян хатан чанар багатай тул спорт-сургалтын зориулалтын өндөр цэцтэй олон төрлийн сумыг үйлдвэрлэх боломж багатай юм.

### 4. Үүсэж болох эрсдэл

Галт зэвсгийн сум үйлдвэрлэх, угсрах, сумны

хэсгүүдийг тээвэрлэх, хадгалах үед гарч болох эрсдэлүүдийн нэг нь тэсрэх болон галын аюул юм.

Эдгээр эрсдэлийн хэсгүүсвэр нь дарь ба бялт асаагуур болох бөгөөд үйлдвэрлэлийн үеийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй арга хэмжээний шаардлагыг ёсчлон дагаж мөрдөөгүй, ноцтой зөрчсөн тохиолдолд л энэ аюул гарах боломжтой.

Дарь бол тэсрэх бодисын нэгэн төрөлд хамаарах бөгөөд шидэлтийн тэсрэх бодис хэмээн нэрлэгдэнэ. Тэсрэх бодисыг хэрэглэгдэх байдлаар нь өдөөлтийн, бутлалтын, шидэлтийн, пиротехникий

ЦЭРЭГ-УРАН ЗОХИОЛ

ГОВИЙН ЗУРАГ

Жил бүрийн өвлийн дунд сарын цан хүүрэг татуулж, цасан ширхэг будуулсан болор өдрүүдэд монгол түмний шимтэн сонсох дуртай Эгшиглэнт эхийн тэргүүн шүлэг тодруулах яруу найргийн наадам болдог билээ. Ардын уран зохиолч Д.Пүрэвдоржийн санаачилсан "Болор цом" яруу найргийн наадам 37 дахь удаагаа зохион байгуулагдлаа. Өнөө жилийн

энэхүү наадам нь орчин үеийн Монголын утга зохиолыг үндэслэгч, Их зохиолч Д.Нацагдоржийн төрсөн нутаг Гүн галуутай буюу Багануур хотод явагдсанаараа онцлог юм. "Болор цом" наадамд хэдэнтэй оролцож явсан, МЗЭ-ийн шагналт яруу найрагч П.Батнайрамдалын шинэ шүлгүүдээр шинэ оны дугаараа мялааж байна.

АГУЙ

Даяанчийн сэрүүн агуйд  
Дахин дахин очих би дуртай  
Угаасаа би хэрмэл удмынх  
Уул хад голомт минь байсан юм  
Дөмөн шуранхай энэ агуйгаас  
Дөрвөн зүг рүү хүлэглэн хатирсан  
Домгийн үргэлжлэл энэ агуйгаас  
Дорнын тал руу хулжиж одсон  
Нам гүм намайг олзлох нь  
Нялхарсан бие дахин төрөх мэт  
Нүгэл, буян үйлийн тойргоос  
Ниссэн шувуу шиг алсарч одно  
Цөм бодлоо дуустал юулж  
Цоо шинэ махбод эндээс гардаг  
Даяанчийн сэрүүн агуйд  
Дахин дахин очих би дуртай

ТУНГААМАЛ

Навч нов ногооноор гэрэлтэж  
Наранд хайрагдан шарлах нь  
Чин хайрын шижир өнгө өө  
Чиний төлөөх тунгаамал аа  
Сүүлчийн тамираа барсан навч  
Сэвэлзэх салхинд тасран унаж  
Чиний хөлд гишгэгдэн үйрэх нь  
Чин хайрын оноогдмол хувь заяа

ХАЙР

Хуучин номын хуудсанд  
Хуучин захидал хавчуулагджээ  
Бэх нь бүдгэрч  
Цаас нь шарласан ч  
Цаанаас нь хайр үнэртэнэ

ХАЙР

Хуучин номын хуудсанд  
Хуучин захидал хавчуулагджээ  
Бэх нь бүдгэрч  
Цаас нь шарласан ч  
Цаанаас нь хайр үнэртэнэ

ХАЙР

Хуучин номын хуудсанд  
Хуучин захидал хавчуулагджээ  
Бэх нь бүдгэрч  
Цаас нь шарласан ч  
Цаанаас нь хайр үнэртэнэ

ҮЙЛ НЬ ИРЭХЭЭР

Үйл нь ирэхээр  
Үүлэн нүүдэл зуун жил уруудаж  
Үнсэн саарал модод ёрдойно  
Үйл нь ирэхээр  
Үймсэн шоргоолж элсжин биежиж  
Үйрч бутарсан чулуу шороо болно  
Үйл нь ирэхээр  
Үзэмж төгс бүсгүй шуламд хувирч  
Үлэмжийн амьдрал утгагүй болно  
Үйл нь ирэхээр  
Үнэнч андууд өстөн дайсан болж  
Үхэжсэн хөндий биетүүд холхилдоно  
Үйл нь ирэхээр  
Үнэтэй бүхэн хөлөөр хөглөрч  
Үнс чандруутай холилдоно  
Үйл нь ирэхээр  
Үйл нь ирэхээр ...

МАЛХЫН ТАЛД БИЧСЭН ШҮЛЭГ

Буурал талын хээлд өнчин дэрс  
Босгосон бийр адил бөхөлзөнө  
Хөндийд аргамжаатай ганц адуу  
Хадны сүг зураг мэт бүртэлзэнэ  
Гэв гэнэт үсэрсэн царцааны дуу  
Гуулин цан хавсрах шиг царгина  
Холыг дурандаж суугаа өвгөн  
Хүн чулуу шиг торойж харагдана

ЦАГ ХУГАЦАА

Илбийн солонго татуулсан  
Агь таанын үнэрт  
Их тал гэрлээр дүүрэх нь  
Ирээдүй биш  
Ирээд буцсан цаг хугацаа  
Идрийн инээдээр дүүргэсэн  
Аглаг нугад  
Өгширсэн яс цайрах нь  
Өнөөдөр биш  
Өмнөөс ирэх цаг хугацаа

ӨВЛИЙН ӨДӨР

Алхах тоолонд нь  
Чахрах авиа хөлдүү  
Сормуус нь цантай бүсгүйд  
Чирэгдэж яваа  
Сүүдэр нь хөлдүү

ХАРИУ

Сөөмхөн суулгасан модны  
Саваа мөчир дух шүргэж байна  
Хажуугаар нь хичнээн өдөр холхио бол  
Хэдийдээ ингэж өндөр ургаа вэ  
Хариу нь миний духны үрчлээс

ЦААСАН ЗАВЬ

Багачуул хөвүүлсэн цаасан завь  
Багахан горхины ховилоор урсана  
Би бодлогошрон эрэгт үлдэж  
Баахан дурсамж ачсан завь  
Бодлын манан сүлбэж цаашилна

ЭРВЭЭХЭЙ

Номын хуудас сөхөхөд  
Өмнөөс ханхийж  
Өрөө дүүрэн зуны үнэр  
Ялдам нэгэн эрвээхэй  
Янзаараа хатаагджээ

ЗУНЫ ҮДЭШ

Нам гүмд олзлогдсон  
Саглагар модны дороос  
Салхи гэнэт өндийхөд  
Зүүрмэг болжмор, уйтгар хоёр  
Зэрэг дэрхийнэ

ТОСГОНЫ ӨГЛӨӨ

Цөөрмөөс ниссэн эртэч шувууд  
Цэвцийсэн үүлийг нэвтэлж одно  
Нойрмог нүдээр дүрлэйтэл харж  
Намагт мэлхий гуаглаж хоцорно  
Молдавын модот аглаг толгод  
Мөрөөдлөө сандчаан сэрж байна  
Толгодын нөмөрсөн дулаан манан  
Тунарч шингэрээд дээшилж байна

АМЛАЛТ

Борооны шиврээ, цасны будраа  
Бударганат талын таанын үнэр  
Болжморын жиргээг чамд амлая  
Бургас цэцэгс, солонгын өнгө  
Булаг шанд, эрвээхэйн дэвэлт  
Бүхнийг чамд амлая, бүсгүй минь  
Өөрийнхөө хайртай бүхнийг амлая  
Өөртөө үлдээхгүйгээр амлая, гэвч  
Өөрийгөө л би амлаж чадахгүй  
Өөрөө би өрөөлийнх болчихвол  
Өмнөх болоод хойт насандаа  
Өртэй хоцрох байлгүй, хөөрхий

Ээрэгч салхины гишгэгдлээр  
Элсний үелээ тодорно  
Эвхрэгч зэрэглээн дунд  
Элрэгч шувуу эргэлдэнэ  
Тэнхээгээ шавхсан заг  
Тэмээгээ дуурайж өтөлнө  
Тоорой модны сүүдэрт  
Тоглоомын чулуу цайрна

НАМРЫН ӨДӨР

Хэсүүл босуул салхинд  
Хамхуул шидэгдэж өнхөрнө  
Хялганын толгой шүүдэр гээнд  
Уйтай модод навч гээнд  
Уг бие минь нас гээнд

ДҮРСЛЭЛ

Дүүрэн ойгоос үлдсэн  
Дүлий саарал хожуул дээр  
Далавчгүй хэрээ гуаглах нь  
Дараа зууны  
Дүрслэл ажаам

НУТГАА САНАСАН АГШИН

Атлантын далайн эрэгт  
Аргалын утаа цэнхэртэв  
Сүрлэн овоохой дайвалзаж  
Сүрэг цахлай үймэлдэв  
Ялаа шумуул дайжиж  
Явуулын хүмүүс сэртэлзэв  
Атлантын далайн эрэгт  
Аргалын утаа суунаглахад  
Далдуу модны сүүдэр  
Далд ортлоо бүдгэрэв  
Атлантын далайн эрэгт  
Аргалын утаа цэнхэртэхэд  
Алсад адуу янцгааж  
Хүлэг морьдын төвөгөөн  
Атлантын далайн түрлэг  
Хуйлран буцах давалгаа

Фрийтаун

АЛТАН ЗООС ШИГ САР

Загасчны хөлөг далбилзуулан  
Хитэг долоож буцах түрлэг  
Шөнийн сэрүүнийг хөтөлж одно  
Атлантын далайн задгай мандалд  
Алтан зоос шиг сар хөвнө

Фрийтаун

БОРОГ ӨВС

Хөхөрч цайрсан яс  
Хөх өвсөн дунд хэвтэнэ  
Үжирч үзэгдэхгүй боллоо ч  
Босоо явсных нь гэрч  
Борог өвс өндийнө

ЭМГЭН

Гэрийн хаяанд бөртөлзөх  
Гандсан тэрлэгтэй эмгэн  
Гүвээ давуулан саравчилна  
Гөлгөр модны мөчирт  
Гундаж сэмэрсэн хадаг

АНИРГҮЙ ХЭЭР

Аниргүй хээрийн сүүлчийн тасархай би  
Аажимдаа аниргүй хээртээ нэгдэх юм  
Төсөөлөл минь гудамжнаас хальж  
Тэнгэрийн хаяа руу шургахад  
Таанын толгой бөхөлзүүлсэн талд  
Тэрлэг нь гандсан эртэй тааралдана  
Аавын минь үргэлжлэл  
Адууны үнэртэй хээр тал минь  
Чийг ханхлуулсан намайг танихгүй  
Чимээгүй дүнсний алсарна  
Хүүгээ голоогүй ээж тал минь  
Хүрээд ирсэнд баярлан уужирна  
Аниргүй хээрийн сүүлчийн тасархай би  
Аажимдаа аниргүй хээртээ нэгдэх юм

ХЭЭР ТАЛ

Ширхэг саарал чулуу нь нүдэнд  
Шижир алт шиг харагдтал  
Тив алгассан зайнаас би  
Тэмүүлж нутгаа зорьсон доо  
Хүрэн бор толгодын дунд  
Хүүхэд шиг нялхран алхахад  
Хэний үнэр вэ, таашгүй  
Хээр тал минь ямархан дотно

ДАРХАНЫ УЛИАС

Далдуу модны  
Сүүдэр дор суухуйяа  
Даллаж дуудаад  
Салхи сэвэлзүүлэх нь  
Дарханы улиас  
Дэвүүр модны  
Далавчин дор суухуйяа  
Дөтөлж алсраад  
Сэтгэл гэгэлзүүлэх нь  
Дарханы улиас

Африк

АТЛАНТЫН ЭРЭГТ

Хөх алаг цахлай гэнэт  
Харвасан сум шиг шунганана  
Хөөс сахруулсан давалгаа  
Хойноос нь элдээд номхорно  
Тэнчээ манхан их түрлэг  
Тэнгэрийн цээлээр цэнхэртэнэ  
Зомгол шиг харагдах завь  
Захалж дөтлөн наашилна  
Эрчээрээ ирсэн давалгаа  
Эргээ долоож цалгина  
Сэвүүр модны сүүдэрт  
Сэтгэл багтахгүй халгина

Африк

ГАЦААНД БИЧСЭН ШҮЛЭГ

Цуурын хоолойт бяцхан шувуу  
Царс модны мөчир жимбүүрдэнэ  
Хураа юулж хөнгөрсөн үүлс  
Хойд зүгийн салхинд уруудна  
Цөөрмийн усанд хэдэн ангир  
Цээжээ жиндээж зөрөлчөн хөвнө  
Өмхөрсөн хожуулын сүүлчийн өтийг  
Өрөвтас зууж эсэргэн зүгт одно

Украин

АТЛАНТЫН ЭРЭГТ БИЧСЭН ШҮЛЭГ

Долгиондоо сар хөвүүлсэн их усан  
Давлан халгин завь далбилзуулна  
Сэвхтэй сарны асгар мөнгөн туяан дор  
Сэрүү татуулан загасны үнэр цоргино  
Мандалдаа одод хүлхсэн их усан  
Мөлгөр хитэг долоож мушгиран буцна  
Салхинд туугдсан суварга цагаан үүлс  
Сэтгэмжийн хязгааргүй эрчлэн цаашилна

Африк



## Дугаарын зочин

Монголын Зохиолчдын Эвлэлийн шагналт, яруу найрагч О.ЦЭНД-АЮУШИЙГ энэ удаагийн зочны хойморт урилаа.

# ТУСАЛЪЯ ГЭВЭЛ ЦЭРГИЙН ДАРГА НАРЫН ӨРӨӨНИЙ ҮҮДЭНД ОДОО Ч ОЧИХОД БЭЛЭН БАЙНА



### ДАЙНЫ МОРЬД

Дэлхийн II дайнд оролцсон монгол морьдын дурсгалд

Нэхмэл даавуу байхаа  
Нэгэнт больсон орхимж  
Хамаг лам нарын биеэс  
Хайлж урсганы дараа

Хойш нь авч явсан бурхдаар  
Хонгио сум хийж  
Орос цэргүүд Германыг  
Онилж буудаж байхад

Суман дотор суусан монгол бурхад  
Судас нь зогссон дайсныг  
Шархан дотроос нь эхэлж  
Шамбал руу чирж байсныг

Дайнд оролцсон манай морьд  
Дандаа олж хардаг байлаа

2019 он.

### САШАГИЙН ЗАХИА

(Орос цэргийн дурсгалд)

Сайн байна уу?

Орос цэргийн ээжээ

Олон жилийн өмнө та нэг хүүтэй байсан даа

Одоо л тэр ачлалгүй хүү чинь

Ээжтэй байснаа гэнэт санасан юм шиг

Энэ захиаг бичиж байна

Нөхөд минь миний дэргэд хэвтээд

Нөгөө л нэг гунигтай орос дуунуудаа

Нөмөрсөн шинелийнхээ цаанаас дуулж байна

Орос дуу шиг ийм сайхан дуу

Одоо байдаг болов уу, ээжээ

Дүү нар минь том болсон уу, ээжээ

Дүүрэн цэрэг ачсан галт тэрэгнүүд, ялалтын дараа

Дүүлэн, дүүлэн төмөр зам дээгүүр давхиж очиход

Дүр төрх нь аавтайгаа л адилхан болсон доо гэж

Өртөөн дээр та минь цэцэг бариад

Өдөржин зогссон уу, ээжээ

Өөдөөс чинь бууж очоогүй болохоор

Өнчирсэн үү, ээжээ

Монголоос очсон галт тэрэгнүүдийн

Модон бүхээг рүү та өнгийсөн үү, ээжээ

Эсвэл би хүүгээ таньсангүй гээд

Эр цэрэг болгоныг эгцэлж харсан уу, ээжээ

Энэ миний хүү биш байна гээд

Эмгэн болтлоо намайг хүлээсэн үү, ээжээ

Хүү чинь тулалдаанд түрүүлж орж

Хүршийн толгой шиг улайдсан ширэм дундуур давшиж

Хаана ч байхгүй

Хатуу өргөстэй бэхлэлтийг шүдээрээ тасдаж

Дайзтай сумаа дуустал

Дайсантай дайтан, ээжээ

Бууныхаа хошуунд жадаа өлгөж

Бууж өгөхгүй эцсээ хүртэл тулалдсан

Төрсөн бие минь хүнд шархдахаас өмнөхөн

Төмөр жад минь нугарсан, ээжээ

Амь үрэгдсэн нөхрөөсөө

Авсан сумаараа буудах гэтэл

Гол тасрахын өмнөхөн

Гох хугарсан, ээжээ

Урдуур, хойгуур улилдаж байсан

Улаан ширэмнүүд гарыг минь авсан, ээжээ

Дайсны пулемётын суманд

Дайруулсан хөл минь

Уг нь ногоон байсан ч

Улаан болсон өмдөн дээрээ тогтож байхад

Үлдсэн ганц гараараа хүү чинь дуулгаа далайгаад

Үхлийн өмнөхөн давшиж байсан, ээжээ

Халхын голоос одоо та хүүгээ

Харьж ирнэ гэж битгий хүлээ, ээжээ

Буудай шиг шаргалхан үстэй Саша чинь

Буудуулчихсан юм аа, ээжээ

Одоо та намайг эндээс

Олохгүй л байх даа ээжээ

Оросынхоо газар шороонд л

Очиж хэвтэх юм сан, ээжээ

2019 он

Ингэхэд та хэзээ хамгийн эхний шүлгээ бичсэн юм бэ? Харин хамгийн сүүлд ямар шүлгээ тэрлэсэн бэ? Тэр хооронд үзэл бодол, сэтгэлгээний их зөрүү байгаа байх даа ...

-Анх хөдөөний хүүхэд морь малын тухай л юм бичсэн. Сүүлд "Цастай уул" гэж шүлгээ бичсэн. Зөрүү зөндөө юм

байхгүй дээ. Гэхдээ бага наснаасаа өөр болоогүй байх. Өөр болохгүй байсан нь л дээр байх. Нэг их "том хүн" болох гээд яах юм бэ. Хүн ер нь өөрийгөө том, жижиг болгодоггүй юм. Хүн тэгж чадахгүй, тийм боломж ч байхгүй. Зөвхөн он жилүүд л хүнийг шалгана. Том болгохоо том болгоно.

Мэдээж та бол шүлэг, найрагараа эх орон, эр цэргээ магтаж явдаг мөрдэсгүй байлдагч. "Эх орны цэрэг" яруу найргийн наадамд цөөнгүй удаа шүлгээ сойж, 2019 онд түрүүлсэн ...

-Би 1939 оны Халхын голын байлдаан, 1945 оны Чөлөөлөх дайны тухай өөрийн хэмжээнд судалсан. Тэр дайнуудын үнэ цэнийг мэднэ. Хүмүүс зүгээр л нэг хэдэн хүн очоод кинон дээр гардаг шиг буудалцаад л дуусчихсан юм шиг бодоод байдаг. Гэтэл үгүй шүү дээ. Цус, нулимс, харуусал, гүтгэлэг, доромжлолыг дайн гэдэг байх. Бидний төлөө хэн яаж, хэзээ яасан, хэрхэн дууссаныг л мартаж болохгүй. Өөрийн сайндаа монгол эхээс төрчихсөн юм биш шүү дээ, бид. Бидний өмнөх аугаа эрчүүдийн байгуулсан гавьяа, урсгасан цус, алдарсан амины буянаар өнөөдөр эрлийз, хурлийз болчихоогүй байна. Тийм болохоор би Монгол Улсын Зэвсэгт хүчин, Хилийн цэргээ дандаа баярлаж, алба хаагчдыг нь хүндэтгэж явдаг. Хамгийн их итгэж явдаг даа. Эх орныхоо төлөө хэрэгтэй цагт нь амиа өгч чадах цог жавхлантай цэрэг дайчдаа баярлалаа, дархан хил дээр цэцэн буугаа үүрээд зогсож байгаа хилчин танд талархлаа. Төрийн сүлдэндээ залбирдаг шиг, та нартаа залбирч явдаг шүү.

Эх орон, эр цэргийн тухай шүлэг таны уран бүтээлийн хэдэн хувийг эзэлж байна вэ?

-Сүүлийн үед нэлээд бичих болсон. Дайн гэж юу байсан, юу болох, ялалт гэдэг ямар их үнэ цэнээр олдсон мэдэхийн хэрээр бичих болжээ. Цаашдаа ч бичсээр л байх болно. Мөн эртний монголчуудын түүхийн тухай бичихийг бодох юм. Заримдаа шүлэг гэхээсээ илүүтэй хөрөг нийтлэл нэлээд бичсэн дээ. Монголын радиогийн "Алтан сан"-д нэлээд юм бий. Улсын баатрууд, хилчдийн тухай зөндөө бичсэн. Мөн баруун хилээр явж, тэнд яг юу болсныг нэг бүрчлэн бичиж, нэр нь тодорсон баатруудын хийгээд нэр нь тодроогүй ч аугаа их гавьяа байгуулсан баатруудын талаар бичих юм сан, сайхан ном бүтээх юм сан гэж бодох юм. Дэмжээсэй билээ. Зарим нэг нь Баруун хилийн тулгаралтыг ердөө мөргөлдөөн төдийнөөр ярьдаг. Үгүй юм аа. Төрийн жил үргэлжилсэн аймшигт дайн байсан юм шүү. Хорь орчим мянган монгол цэрэг эх орныхоо төлөө тэнд алтан амиа алдсан юм шүү дээ. Үрх зүсэгдмээр шүү. Нэг л жишээ хэлье. Эцсээ хүртэл тулалдаад амь үрэгдсэн Б.Тэгшээгийн хөл нь борвиороо тас үсрээд, чөмөгнийх нь ясанд шороо, чулуу чихчихсэн байсан юм. Өнөөдөр бид ийм түүхийг мартаад байгаа болохоор тэнгэлээд байгаа юм шиг байна. Өөрөөр хэлбэл, энэхүү эрх чөлөө, тусгаар тогтнол нь ямар их үнэ цэнээр олдсон юм бэ гэдгээ мэдэхгүй байна. Тийм болохоор энэ тухай бичих л хэрэгтэй байна даа. Чөмөгнийхөө ясанд шороо, чулуу чигжүүлж байж биднийг тэд минь гишгэх газартай үлдээсэн юм шүү дээ.

Ямар цаг үед цэрэг дайчдынхаа тухай шүлэг бичмээр санагддаг юм бэ?

-Сайхан мөртүүд урсаад л ирдэг юм даа. Эх орны тухай бодлууд, эх орончдын, амь үрэгсдийн тухай бодлууд. Одоо миний цээжинд Баруун хилийн тулгаралтын тухай бичих бодлууд л дараатай байна. Шүлэг, дууль, кино, баримтат кино, хөрөг нийтлэл бичих, бүтээх санаа их байна. Магад бүтэх биз дээ. Тэд бичүүлэх биз.

Тэд гэж хэн бэ?

-Тэнгэрт байгаа баатрууд. Эх орноо амиараа хамгаалсан цэрэг эрс минь.

Сайхан хариулт байна. Та 2019 онд сэтгүүл зүйн радиогийн төрөлд шилдгээр шалгарсан байсан. Ингэхэд та Монголын радиотой хэзээнээс холбогдсон юм бэ? Цэндийн Чимэддорж хэмээх их хүмүүний орыг залгаж, түүний "Малчин" болоод бусад нэвтрүүлгүүдийг буухиалан залгаж яваа байх аа ...

-Би Монголын радиод 10 дахь жилээ ажиллаж байна. Монголын радиотой бид бүгдээрээ холбогдсон хүмүүс шүү дээ. Багадаа радио л сонсдог байсан биз дээ?

Тийм ээ, бөхийн барилдаан бас үлгэрийн цаг их сонсдог байсан ...

-Тийм байгаа биз. Хүн бүр л радио сонсож өссөн юм. Миний хувьд хожим эндээ ажиллаж эхэлсэн. Манай радиогийн хамт олон сайхан шүү. Үүргээ үнэнчээр биелүүлж, зөвхөн үнэн мэдээллийг л сонсогчдоод цацаж байдаг. Яах вэ, зарим хүн одоо Монголын радио гэж байдаг юм уу гэж асуудаг. Байхаар барах уу даа. Сүүлийн үед хэвлэл мэдээллийн хэрэгсэл олширсон, тэрийг нь дагаад хүмүүс ч өөрчлөгдөж, Гэвч муу үг хэлж байгаа юм биш. 7-8 баллын хүчтэй газар хөдлөхөд ганцхан Монголын радио л дуугарна. Телевизүүд яах юм бэ, гарахгүй, сонин хэвлэгдэж чадахгүй. Тийм болохоор 85 жилийн түүхтэй Монголын радио хэзээд байсаар ч байна.

2019 онд Халхын голын байлдааны тухай 200 минутын нэвтрүүлгээрээ "Ган үзэгтэн" болсныг цахим хуудаснаас тань харсан. Цэрэг дайчдынхаа талаар чимээгүй хөдөлмөрлөж байгаа танд баярлалаа ...

-Тэргүүндээ соёмбо залсан цэрэг дайчдаа бид л хайрлаж, алдар сууг нь мөнхлөхгүй бол өөр хэн гэж. Бичихэд хүртэл тун урамтай сэдэв. Нээрээ надад БХЯ, ЗХЖШ-ын удирдлагад илгээх нэг хүсэлт байна. Баруун хилийн тулгаралтын талаар судалгаа хийж, газар орноор нь хөндлөн туучиж, нэр нь тодроогүй аугаа их баатруудын тухай сайхан бүтээл туурвихад минь тусалж дэмжээрэй. Тусалъя гэвэл цэргийн дарга нарын өрөөний үүдэнд одоо ч очиход бэлэн байна.

Таны уран бүтээлд өндөр амжилт хүсье.

Дэслэгч Д.БОЛОРМАА

### Зэвсэгт хүчний тээврийн хяналтын албанаас мэдүүлж байна

Хувиараа такси үйлчилгээ эрхлэгчид болон бусад иргэд, чиглэлийн тээврийн хэрэгслийн буудал зогсоолд зогсох зөрчлийг ихээр гаргаж байгаатай холбогдуулан нийтийн тээврийн том оврын автобусанд зөрчил илрүүлэгч камер суурилуулсан байна.

Уг камераар Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 14.8 заалтыг зөрчсөн зөрчлийг илрүүлж, тээврийн хэрэгслийн эзэмшигчийн гэрийн хаягаар торгууль хүргүүлэх болсон байна. Иймд тээврийн хэрэгсэл эзэмшигчдэд чиглэлийн тээврийн хэрэгслийн буудалд зогсохгүй байхыг анхааруулъя.

Урьдчилан сэргийлэх, олон нийттэй харилцах мэргэжилтэн, цагдаагийн дэслэгч Д.ГАНХУЯГ

**СОЁМБО СОНИН**  
"Соёмбо" сонин 95 дахь жилдээ хэвлэгдэж байна.  
Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА,  
Д.НАЦАГДОРЖ

Эрхлэгч  
Хурандаа  
Батжаргалын  
ОТГОНБАЯР

Эхийг "Соёмбо" сонин  
релакад бэлтгэж,  
"Соёмбо принтинг" хэвлэх  
үйлдвэрт хэвлүүлэв.

\*Зар, рекламьг хямд нийтэлнэ.  
\*Зар, рекламьн үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.  
\*Зохиогчийн үзэл бодол сонин нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.  
\*Тус сонин мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот,  
Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон  
Индекс 10018  
И-мэйл хаяг:  
Mil\_newssoyombo@yahoo.com  
Утас: 70001029